

**Хөдөлгөөн засалч мэргэжлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох
шалгалтын жишиг сорил**

Сорилын зөв хариулт

1-C, 2-D, 3-A, 4-E, 5-B, 6-A, 7-A, 8-A, 9-B, 10-D, 11-C, 12-B, 13-B, 14-B, 15-C, 16-B, 17-A, 18-B, 19-D, 20-A, 21-C, 22-A, 23-C, 24-B, 25-D, 26-E, 27-C, 28-A, 29-E, 30-B, 31-A, 32-C, 33-E, 34-C, 35-A, 36-D, 37-A, 38-C, 39-A, 40-C, 41-B, 42-C, 43-C, 44-C, 45-B, 46-D, 47-B, 48-E, 49-A, 50-B, 51-A, 52-A, 53-A, 54-C, 55-A, 56-C, 57-A, 58-A, 59-C, 60-A, 61-C, 62-C, 63-E, 64-B, 65-C, 66-E, 67-C, 68-B, 69-A, 70-B, 71-A, 72-D, 73-B, 74-A, 75-A, 76-C, 77-A, 78-A, 79-B, 80-E, 81-E, 82-B, 83-A, 84-C, 85-C, 86-A, 87-A, 88-E, 89-A, 90-A, 91-A, 92-C, 93-E, 94-C, 95-C, 96-B, 97-A, 98-C, 99-D, 100-A, 101-C, 102-C, 103-B, 104-E, 105-A, 106-E, 107-E, 108-C, 109-C, 110-C, 111-A, 112-E, 113-C, 114-E, 115-D, 116-C, 117-A, 118-A, 119-E, 120-E, 121-B, 122-D, 123-A, 124-C, 125-A, 126-A, 127-A, 128-E, 129-C, 130-B, 131-A, 132-B, 133-B, 134-B, 135-C, 136-E, 137-C, 138-C, 139-C, 140-C, 141-C, 142-C, 143-A, 144-B, 145-B, 146-B, 147-D, 148-B, 149-B, 150-B, 151-A, 152-C, 153-E, 154-E, 155-A, 156-C, 157-A, 158-A, 159-C, 160-A, 161-C, 162-A, 163-C, 164-B, 165-A, 166-C, 167-C, 168-A, 169-B, 170-C, 171-A, 172-B, 173-B, 174-C, 175-B, 176-B, 177-C, 178-B, 179-B, 180-A, 181-B, 182-A, 183-A, 184-B, 185-C, 186-B, 187-C, 188-A, 189-B, 190-A, 191-C, 192-A, 193-C, 194-C, 195-C, 196-A, 197-C, 198-D, 199-B, 200-B, 201-C, 202-A, 203-A, 204-B, 205-B, 206-A, 207-D, 208-A, 209-A, 210-A, 211-A, 212-A, 213-C, 214-A, 215-C, 216-A, 217-C, 218-C, 219-D, 220-B, 221-B, 222-C, 223-A, 224-C, 225-C, 226-A, 227-C, 228-A, 229-D, 230-C, 231-A, 232-B, 233-B, 234-A, 235-A, 236-B, 237-E, 238-C, 239-D, 240-A, 241-A, 242-B, 243-E, 244-C, 245-B, 246-A, 247-C, 248-D, 249-A, 250-B, 251-B, 252-D, 253-A, 254-E, 255-D, 256-A, 257-C, 258-B, 259-C, 260-C, 261-B, 262-A, 263-A, 264-D, 265-B, 266-B, 267-A, 268-C, 269-C, 270-B, 271-C, 272-B, 273-A, 274-D, 275-B, 276-A, 277-B, 278-B, 279-A, 280-B, 281-B, 282-C, 283-C, 284-B, 285-A, 286-B, 287-B, 288-D, 289-C, 290-D, 291-A, 292-B, 293-B, 294-A, 295-C, 296-A, 297-A, 298-A, 299-A, 300-A, 301-C, 302-C, 303-D, 304-A, 305-A, 306-A, 307-C, 308-E, 309-D, 310-E, 311-A, 312-A, 313-B, 314-D, 315-C, 316-B, 317-A, 318-B, 319-A, 320-A, 321-D, 322-B, 323-C, 324-D, 325-B, 326-A, 327-D, 328-A, 329-D, 330-D, 331-D, 332-B, 333-A, 334-B, 335-B, 336-D, 337-E, 338-A, 339-A, 340-B, 341-B, 342-B, 343-D, 344-A, 345-B, 346-B, 347-B, 348-C, 349-E, 350-A, 351-C, 352-E, 353-B, 354-A, 355-B, 356-E, 357-B, 358-E, 359-A, 360-E, 361-A, 362-E, 363-E, 364-D, 365-A, 366-A, 367-B, 368-B, 369-A, 370-B, 371-E, 372-A, 373-A, 374-E, 375-D, 376-C, 377-C, 378-B, 379-B, 380-D, 381-E, 382-E, 383-D, 384-E, 385-E, 386-E, 387-A, 388-E, 389-D, 390-B, 391-A, 392-A, 393-E, 394-B, 395-A, 396-A, 397-A, 398-C, 399-A, 400-C, 401-A, 402-C, 403-C, 404-D, 405-A, 406-E, 407-A, 408-E, 409-C, 410-E, 411-E, 412-E, 413-C, 414-E, 415-A, 416-C, 417-A, 418-A, 419-A, 420-B, 421-B, 422-A, 423-D, 424-B, 425-D, 426-D, 427-A, 428-A, 429-B, 430-A, 431-C, 432-B, 433-A, 434-A, 435-B, 436-D, 437-A, 438-B, 439-E, 440-D, 441-D, 442-B, 443-B, 444-E, 445-B, 446-B, 447-C, 448-A, 449-C, 450-B, 451-C, 452-D, 453-A, 454-B, 455-A, 456-C, 457-C, 458-D, 459-B, 460-B, 461-D, 462-B, 463-D, 464-A, 465-C, 466-A, 467-C, 468-C, 469-C, 470-D, 471-D, 472-B, 473-A, 474-A, 475-A, 476-B, 477-B, 478-A, 479-B, 480-B, 481-A, 482-B, 483-A, 484-B, 485-E, 486-A, 487-C, 488-B, 489-E, 490-D, 491-E, 492-A, 493-C, 494-A, 495-A, 496-D, 497-A, 498-E, 499-C, 500-C, 501-C, 502-A, 503-E, 504-A, 505-E, 506-D, 507-D, 508-D, 509-C, 510-A, 511-C, 512-D, 513-E, 514-A, 515-A, 516-E, 517-B, 518-B, 519-A, 520-E, 521-C, 522-D, 523-A, 524-B, 525-E, 526-A, 527-E, 528-A, 529-A, 530-E, 531-E, 532-D, 533-B, 534-A, 535-D, 536-E, 537-E, 538-B, 539-C, 540-A, 541-D, 542-B, 543-E, 544-E, 545-E, 546-A, 547-A, 548-A, 549-B, 550-A, 551-B, 552-C, 553-E, 554-C, 555-B, 556-A, 557-B, 558-D, 559-A, 560-A, 561-D, 562-A, 563-D, 564-D, 565-A, 566-C, 567-B, 568-D, 569-B, 570-C, 571-A, 572-B, 573-C, 574-A, 575-C, 576-C, 577-E, 578-A, 579-B, 580-E, 581-D, 582-E, 583-A, 584-C, 585-A, 586-A, 587-A, 588-E, 589-C, 590-E, 591-A, 592-C, 593-B, 594-C, 595-C, 596-D, 597-A, 598-A, 599-E, 600-A, 601-E, 602-E, 603-E, 604-E, 605-E, 606-D, 607-D, 608-E, 609-A, 610-C, 611-E, 612-B, 613-A, 614-E, 615-A, 616-C, 617-E, 618-E, 619-C, 620-C, 621-E, 622-C, 623-A, 624-A, 625-A, 626-A, 627-A, 628-C, 629-A, Сонгогдсон сорил

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ TENS-ийг хийх гол зорилгыг тодорхойлно уу?

- A. Булчингийн хүчийг сайжруулах
- B. Цусны эргэлтийг сайжруулна
- C. Өвдөлтийг намдаана
- D. Уян хатан чанарыг нэмэгдүүлнэ
- E. Бодисын солилцоог сайжруулна

/2./ Олон улсын үйл ажиллагааны ангилал (ICF)-ийн идэвхи ухагдахуунд хамаарах ойлголтыг сонгоно уу.

- A. Бие махбодийн эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа
- B. Бие махбодийн эрхтэн тогтолцоо, мөчид
- C. Бие махбодийн эрхтэн тогтолцооны мөчдийн үйл ажиллагааны алдагдал
- D. Хувь хүний хүсэл зорилгоор хийгдэж буй үйл ажиллагаа
- E. Нийгмийн үйл ажиллагаанд оролцож буй оролцоо

/3./ Олон улсын үйл ажиллагааны ангиллыг зөв харгалзуулна уу?

- A. Орчны хүчин зүйл
- B. Хувь хүний хүчин зүйл
- C. Биеийн бүтэц үйл ажиллагааны ангилал
- D. Идэвхи
- E. Оролцоо

1. Орон сууцны 3 давхартамьдардаг
2. 32 настай, ганц бие
3. 4 толгойт булчингийн хүч суларсан
4. Алхахад бэрхшээлтэй
5. Хөл бөмбөг тоглох боломжгүй

- A. A1 B2 C3 D4 E5
- B. B1 C2 D3 E4 A5
- C. C1 D2 E3 A4 B5
- D. D1 E2 A3 B4 C5
- E. E1 A2 B3 C4 D5

/4./ Эрүүл насанд хүрсэн хүний минутан дахь зүрхний цохилтын тоо хэв байх вэ?

- A. 60-110
- B. 60-100
- C. 70-80
- D. 90-95
- E. 60-90

/5./ 45 настай, үйлчлүүлэгч алхаж чадахгүй, орноос өөрөө босож зогсож чадахгүй, тэргэнцэр ашигладаг гэх түүхтэй. Олон улсын үйл ажиллагааны ангилал (ICF)-аар ямар ухагдахуунд хамаарах вэ?

- A. Бие махбодийн бүтэц, үйл ажиллагааныалдагдал
- B. Идэвхи
- C. Оролцоо
- D. Хувь хүний хүчин зүйл
- E. Орчны хүчин зүйл

/6./ Физикийн хүчин зүйлийг эмчилгээнд хэрэглэх зарчим

- A. Хувь хүний онцлогт тохируулан эмчлэх
- B. Курс эмчилгээ шаардлагагүй
- C. Үйлчлэх эдийн зузаан
- D. Үйлчлэх хүчин зүйлийн эрчим
- E. Цахилгаан соронзон талбайг ашиглах

/7./ Мэдрэхүй, танин мэдэхүйн талаар утгуудыг уялдуулна уу?

- A. Өнгөц мэдрэхүй
- B. Гүний мэдрэхүй
- C. Танин мэдэхүй
- D. Мэдрэхүй
- E. Мэдрэмж

1. Ямар нэг цочруулыг субъектив байдлаар хүлээн авах
2. Цочролын хүчдэл ба шинж чанар, цаг хугацааны явц зэргийг ялгах
3. Ихэвчлэн арьсанд байрлах ба тэмтрүүл өвдөлт дулаан зэргээр ялгах
4. Хөдөлгөөн байрлалаар мэдэрнэ
5. Юмны мөн чанар хийгээд ялгааг мэдэх

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A2 B3 C4 D5 E1
- C. A3 B4 C5 D1 E2
- D. A4 B5 C1 D2 E3
- E. A5 B1 C2 D3 E4

/8./ Хөдөлгөөн засал мэргэжлийн тодорхойлолтыг нэрлэнэ үү?

A. Аливаа өвчин эмгэг, хүрээлэн буй орчин, осол гэмтэл, насжилтын шалтгаант бие махбодийн хөдөлгөөн, үйл ажиллагааны чадвар алдагдал, амьдралын чанарыг хамгийн дээд, боломжит түвшинд сэргээн тогтворжуулах үйлчилгээг үзүүлдэг мэргэжилтэн

B. Үйл ажиллагааны чадвар алдагдал, амьдралын чанарыг хамгийн дээд, боломжит түвшинд сэргээн тогтворжуулах нь ач холбогдолтой

C. Аливаа өвчин эмгэг, хүрээлэн буй орчин, осол гэмтэл, насжилтын шалтгаант бие махбодийн хөдөлгөөн, үйл ажиллагааны чадвар алдагдлыг хамгийн доод, боломжит түвшинд сэргээн тогтворжуулах тусламж үйлчилгээ

D. Үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд чиглэсэн хөдөлгөөн заслын олон талт үйлдлүүдийг хийх чадвартай мэргэжилтэн

E. Гардан ажилбаруудыг чадварлагаар хийж, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, хөдөлгөөн заслын тусламж үйлчилгээг үзүүлэх зорилготой мэргэжилтэн

/9./ Доод мөчний булчингийн хүчний бууралтыг ICF-раль ангилалд хамруулах вэ?

- A. Идэвхи оролцоо
- B. Үйл ажиллагаа болон бүтэц
- C. Хувь хүний хүчин зүйл
- D. Орчны нөлөөлөл
- E. Бүтэц

/10./ Чадах ADL гэж хаана хийж гүйцэтгэхэд чадах вэ?

- A. Гэрт
- B. Гэрт, тасагт, нийгэмд
- C. Тасагт
- D. Сэргээн засах, өрөө, тасагт

Е. Сэргээн засах өрөө

/11./ Суугаа байрлалд туслагч шалгуулагчийн мөрний үеэр 90 градус холдуулсан байрлалд шууг супинаци, пронаци хийлгэх нь булчингийн хүчийг шалгах тестийн хэддүгээр баллын тест вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

/12./ Парафиныг хэдэн хэм хүртэл халаах вэ?

- A. 100-110
- B. 110-140
- C. 120-130
- D. 130-135
- E. 135-140

/13./ Чадах ADL-г ямар үнэлгээгээр үнэлэх вэ?

- A. ESCROW Profile
- B. Barthel Index
- C. FIM
- D. QOL-36
- E. PGC morale scale

/14./ Дараах дасгалын төрлүүдийг тохируулна уу?

- A. Изометрик дасгал 2
- B. Изокинетик дасгал 1
- C. Изотоник дасгал 3
- D. Сунгалтын дасгал 5
- E. Аэробик дасгал 4

1. Том булчингуудын үйл ажиллагааг өөрчлөх хангалттай хэмжээний ачаалалтай, динамик дасгал

- 2. Булчингийн уртын хэмжээг өөрчлөхгүйгээр агших
- 3. Багажийн оролцоотой хурдан агших
- 4. Булчингийн уртын хэмжээ уртсах, богиносох
- 5. Уян хатан чанараа алдсан зөөлөн эдийг механикаар сунгах

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A2 B3 C4 D5 E1
- C. A3 B4 C5 D1 E2
- D. A4 B5 C1 D2 E3
- E. A5 B1 C2 D3 E4

/15./ Үений далайцаар хөдөлгөөн хийгдсэний дараа далайцын төгсгөл хэсэгт эсэргүүцэл үзүүлэх тестийг сонгоно уу.

- A. Идэвхитэй эсэргүүцэлтэй сорил (active resistance test)
- B. Идэвхигүй тест (passive test)
- C. Зогсоох сорил (The break test)
- D. Үений далайц шалгах тест
- E. Булчингийн хүчийг үнэлэх сорил

/16./ ICF ангиллын бүрэлдэхүүнд хамаарагдах бие махбодийн бүтцэд юуг хамруулах вэ?

- A. Өвчний төрх байдлын бүтэц
- B. Эрхтэн болоод анатомийн бүтэц
- C. Эрхтэн болоод физиологийн үйл ажиллагаа
- D. Үйл ажиллагааны мэдэгдэхүйц өөрчлөлт
- E. Үйл ажиллагааны бууралт

/17./ Хөдөлмөрийн хэрэгсэл, багажтай харилцах өдөр тутмын үйл ажиллагаа (ADL)-г сонгоно уу

- A. Хоол хийх
- B. Нүүр угаах

- C. Хувцас өмсөх
- D. Алхах
- E. Шатаар өгсөх

/18./ Хөдөлгөөний хэвтээ хавтгайд булчин дэлхийн татах хүчний эсрэг бага зэрэг эсэргүүцэл үзүүлж агших агшилт булчингийн хүчийг үнэлэх тестийн хэддүгээр балл вэ?

- A. 0
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

/19./ Физик эмчилгээг хэд ангилдаг вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

/20./ Амьсгалын эмгэгийн үеийн хөдөлгөөн засал эмчилгээний ач холбогдлыг зөв харгалзуулна уу?

- A. Амьсгалын тоог нэмэгдүүлэх
- B. Өрцний хөдөлгөөнийг нэмэгдүүлэх
- C. Цэр салст ядгаруулах зөв байрлалд байлгах
- D. Амьсгалд оролцох их биеийн булчингийн үйл ажиллагааг сайжруулах
- E. Доод мөчний булчингийн хүчийг нэмэгдүүлэх

- 1. Бие махбод дахь хүчилтөрөгчийг нэмэгдүүлэх
- 2. Амьсгалд жигд оролцоотой оролцох
- 3. Илүү тааламжтай, илүүдэл шингэнийг гадагшлуулах
- 4. Механик амьсгалыг (орлон булчин) бууруулж
- 5. Бие махбодийн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх

- A. A1 B2 C3 D4 E5
- B. B1 C2 D3 E4 A5
- C. C1 D2 E3 A4 B5
- D. D1 E2 A3 B4 C5
- E. E1 A2 B3 C4 D5

/21./ Олон улсын үйл ажиллагааны ангилал (ICF)-ийн бие махбодийн бүтэц, үйл ажиллагааны ухагдахуунд хамаарах ойлголтыг сонгоно уу?

- A. Бие махбодийн эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа
- B. Бие махбодийн бүтэц, эрхтэн тогтолцоо, мөчид
- C. Бие махбодийн бүтэц, эрхтэн тогтолцоо, мөчдийн үйл ажиллагааны алдагдал
- D. Хувь хүний хүсэл зорилгоор хийгдэж буй үйл ажиллагаа
- E. Нийгмийн үйл ажиллагаанд оролцож буй оролцоо

/22./ Булчингийн хүч үзэх аргыг зөв харгалзуулна уу?

- A. Хөндлөн тэнхлэгт хөдөлгөөн хийнэ.
- B. Идэвхигүй хөдөлгөөн хийлгээд булчинг тэмтрэхэд булчингийн агшилт тэмтрэгдэнэ
- C. Үений далайцаар идэвхитэй хөдөлгөөн хийнэ
- D. Үений хөдөлгөөнд бага зэргийн эсэргүүцэлд тэсвэртэй
- E. Үений хөдөлгөөний их эсэргүүцэлд тэсвэртэй

- 1. 2 балл
- 2. 1 балл
- 3. 3 балл
- 4. 4 балл
- 5. 5 балл

- A. A1 B2 C3 D4 E5
- B. B1 C2 D3 E4 A5
- C. C1 D2 E3 A4 B5

D. D1 E2 A3 B4 C5

E. E1 A2 B3 C4 D5

/23./ Фотодинамик эмчилгээг ямар өвчний үед хэрэглэх вэ?

A. Хоргүй хавдар

B. Элэгний үрэвсэл

C. Хорт хавдар

D. Бамбай булчирхайн дутагдал

E. Улаан хоолойн хоргүй хавдар

/24./ Иллэг (stroking) эмчилгээний тодорхойлолтыг нэрлэнэ үү?

A. Эрхий хурууг ашиглан үрэлцүүлэх арга

B. Тайвшруулах зорилгоор булчингийн ширхэгийг зөөллөх арга

C. Хоёр алгаар зөөлөн тогших иллэг хийх арга

D. 4 мөчийг сэгсэрч тайвшруулах арга

E. Булчингийн ширхэгийн дагуу аажим гүн дараниллэг хийх арга

/25./ Тамхи таталтыг ICF-р аль ангилалд хамруулах вэ?

A. Үйл ажиллагаа

B. Идэвхи

C. Оролцоо

D. Хувь хүний хүчин зүйл

E. Бүтэц

/26./ Шаврыг хэсэг газарт хэдэн хэмтэй тавих вэ?

A. 20-25

B. 25-30

C. 30-35

D. 35-40

E. 40-45

/27./ Д нь дунд сургуулийн багш мэргэжилтэй тархины харвалтын улмаас сэргээн засах эмчилгээ хийлгэж байгаа бөгөөд цаашид хичээлээ үргэлжлүүлэн заах хүсэлтэй, шатрын спортоор хичээллэдэг гэх ба Олон улсын үйл ажиллагааны ангилал (ICF)-аар ямар ухагдахуунд хамаарах вэ?

A. Бие махбодийн бүтэц, үйл ажиллагааны алдагдал

B. Идэвхи

C. Оролцоо

D. Хиувь хүний хүчин зүйл

E. Орчны хүчин зүй

/28./ Үений далайцаар хөдөлгөөн хийхийн өмнө үндсэн байрлалаас эсэргүүцлийн эсрэг хөдөлгөөн хийх тестийг сонгоно уу?

A. Идэвхигүй эсэргүүцэлтэй сорил

B. Идэвхигүй сорил

C. Зогсоох сорил

D. Үений далайц шалгах сорил

E. Булчингийн хүчийг үнэлэх сорил

/29./ Усан сандусны хэмжээ цээжээр татах гүнд урагш алхах үед цээжинд ирэх даралтыг тодорхойлно уу?

A. Гидростатик даралт

B. Үрэлтийн хүч

C. Татах хүч

D. Усны эргүүлэх хүч

E. Долгионыг эсэргүүцэх хүч

/30./ Эрүүл насанд хүрсэн хүний амьсгалын тоо хэд вэ?

A. 12-18

B. 16-20

C. 20-21

D. 16-24

E. 18-26

/31./ Үений хэлбэр болон булчингийн үйл ажиллагааг уялдуулна уу?

- A. Нэг тэнхлэгт үе
- B. Хоёр тэнхлэгт үе
- C. Олон тэнхлэгт үе
- D. 2 тодгойт булчин
- E. 3-н толгойт булчин

1. Тохойн үеэр нугалах хөдөлгөөн хийнэ
2. Тохойн үеэр тэнийлгэх хөдөлгөөн хийнэ
3. Хүүрууны үе, тохой шагайн үе болон богтос ясны үеэс бүрдэнэ
4. Өвдөг, цээжний эгэмний үе болон эрхий хуруу, алга, бугуйн үеэс бүрдэнэ
5. Мөр, түнхний үе, багана нуруу, ууцны үеэс тус тус бүрдэнэ

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A2 B3 C4 D5 E1
- C. A3 B4 C5 D1 E2
- D. A4 B5 C1 D2 E3
- E. A5 B1 C2 D3 E4

/32./ Сунгалтын дасгалыг хэдэн секунд барьж хийх нь тохиромжтой вэ?

- A. 10-20 сек
- B. 5-15 сек
- C. 15-30 сек
- D. 15-20 сек
- E. 1-25 сек

/33./ Чадаж буй ADL гэж хаана хийж гүйцэтгэхэд чадах вэ?

- A. Эмнэлэгт
- B. Гэрт
- C. Гэрт, тасагт, нийгэмд
- D. Тасагт
- E. Эмнэлэгт, гэрт, нийгэмд

/34./ Суугаа байрлалд хоёр мөрөө өргөж чадах нь булчингийн хүч шалгах тестийн хэддүгээр баллын тест вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

/35./ Дараах үений далайцыг хэмжих утгуудыг уялдуудна уу?

- A. Түнх нугалах үений далайц 1
- B. Түнх тэнийлгэх үений далайц 2
- C. Түнх гадагш эргүүлэх үений далайц 3
- D. Түнх дотогш эргүүлэх үений далайц 4
- E. Өвдөг тэнийлгэх үений далайц 5

1. Дээш харж хэвтсэн байрлалд өвдөг нугалж, түнхний үеэр идэвхитэй нугалуулна.
2. Дээш харж хэвтсэн байрлалд хөл дээшээ өргөнө.
3. Дээш харж хэвтсэн байрлалд өвдөг 90 градус нугалуулж, түнхний үеэр 90 градус нугална. Энэ байрлалаас хөлийг дотогш эргүүлэх
4. Дээш харж хэвтсэн байрлалд өвдөг 90 градус нугалуулж, түнхний үеэр 90 градус нугална. Энэ байрлалаас хөлийг гадагш эргүүлэх
5. Дээш харж хэвтсэн байрлалд хөл тэнийлгэж, шагайн үений дор алчуур ивнэ.

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A2 B3 C4 D5 E1
- C. A3 B4 V5 D1 E2
- D. A4 B5 C1 D2 E3
- E. A5 B1 C2 D3 E4

/36./ Өдөр тутмын үйл ажиллагаа (ADL)-ны үндсэн үйлийг сонгоно уу

- A. Утсаар ярих

- B. Гэр цэвэрлэх
- C. Хоол хийх
- D. Өөрийгөө асрах (нүүр гар угаах, хоол идэх, босох, суух....)
- E. Зурагт үзэх

/37./ Дараах рефлексүүд хэдэн сартайгаас алга болох вэ?

- A. Моро рефлекс
- B. Атгах рефлекс
- C. Ландау рефлекс
- D. Бабинский рефлекс
- E. ATNR

1. 4-6 сартайд
 2. 1-2 сартайд
 3. 24-30 сартайд
 4. 24 сартайд
 5. 4-6 сартайд
- A. A1 B2 C3 D4 E5
 - B. A5 B1 C2 D3 E4
 - C. C1 D2 E3 A4 B5
 - D. D1 E2 A3 B4 C5
 - E. E1 A2 B3 C4 D5

/38./ Насыг ICF-р аль ангилалд хамруулах вэ?

- A. Идэвхи оролцоо
- B. Үйл ажиллагаа болон бүтэц
- C. Хувь хүний хүчин зүйл
- D. Орчны нөлөөлөл
- E. Бүтэц

/39./ Тааз, гуяны ямар хэсгүүдийг тэмтрэх вэ?

- A. Суудал яс
 - B. Дунд чөмөгний их төвгөр
 - C. Гуяны артер
 - D. Дөрвөн толгойт булчин
 - E. Ойртуулагч булчин
1. Ischiadic tuber
 2. Greater trochanter
 3. Femoral arter
 4. Quadriceps femoris muscle
 5. Adductor muscle
- A. A1 B2 C3 D4 E5
 - B. B1 C2 D3 E4 A5
 - C. C1 D2 E3 A4 B5
 - D. D1 E2 A3 A4 B5
 - E. E1 A2 B3 C4 D5

/40./ Нүдэнд үзэгдэх гэрэл хүний биед хэдэн см гүнд нэвтэрдэг вэ?

- A. 0.5-1.5 см
- B. 1-0.5 см
- C. 1-1.5 см
- D. 1-2 см
- E. 1.5-2см

/41./ 7 сартай хүүхэд сууж байх үед биеийн тулгуур цэг аль хэсэгт орших вэ?

- A. Гуяны хэсэгт
- B. Өгзөг, гуяны хэсэгт
- C. Хэвлий, өгзөг хэсэгт
- D. Гуя, шагайн хэсэгт
- E. Өгзөг, шагайн хэсэгт

/42./ ICF-ийн хам хүчин зүйлийг тодорхойлно уу.

- A. Идэвхи
 - B. Оролцоо
 - C. Орчны хүчин зүйл
 - D. Үйл ажиллагаа
 - E. Бүтэц болон үйл ажиллагаа
- /43./ Хасах цэнэгтэй эмийн бодис аль нь вэ?
- A. Адреналин
 - B. Алое
 - C. Аскорбины хүчил
 - D. Кальцихлорид
 - E. Дикайн
- /44./ Чадаж буй ADL-г ямар үнэлгээгээр үнэлэх вэ?
- A. ESCROW Profile
 - B. Barthel index
 - C. FIM
 - D. QOL-36
 - E. PGC Morale scale
- /45./ ICF ангиллын онцлог юу вэ?
- A. Хөдөлгөөн заслын практикт элбэг тохиолдох өвчнийг ангилдаг
 - B. Үйл ажиллагааны чадвар алдалтаар ангилдаг
 - C. ADL үнэлэхэд ач холбогдолтой
 - D. QOL үнэлэхэд ач холбогдолтой
 - E. Орчны нөхцлийг үнэлдэг
- /46./ Экцентрик дасгалыг тодорхойлно уу?
- A. Булчингийн ажил хийгдэхгүй, их хэмжээний хүч гаргах дасгал
 - B. Булчингийн агшилтын хурдыг багажийн тусламжтай хянах дасгал
 - C. Үений тогтвортой байдлыг сайжруулах дасгал
 - D. Гадны эсэргүүцлийн нөлөөгөөр булчин уртсаж, агшиж хийгдэж буй дасгал
 - E. Хөл гарын дистал хэсэг тулгууртай хийх дасгал
- /47./ Насанд хүрээгүй хүүхдийг судалгаанд хамруулах тохиолдолд хэний зөвшөөрлийг авах вэ?
- A. Өөрийн зөвшөөрөл
 - B. Хууль ёсны асран хамгаалагч
 - C. Тухайн цэцэрлэг, сургуулийн эрх бүхий иргэний зөвшөөрөл
 - D. Найз нөхдийн зөвшөөрөл
 - E. Зөвшөөрөловах шаардлагагүй
- /48./ Суугаа байрлалд өвдөг нугалсан байрлалд түнхний үеэр гадагш эргүүлж, нугалсан байрлалд гаднаас өгсөн эсэргүүцлийг тэсвэрлэх нь булчингийн хүчийг шалгах тестийн хэддүгээр баллын тест вэ?
- A. 0
 - B. 1
 - C. 2
 - D. 3
 - E. 4
- /49./ Алхааны хэлбэр болон алхааны биомеханикийг уялдуулна уу?
- A. O хэлбэрийн алхаа
 - B. X хэлбэрийн алхаа
 - C. Хайч хэлбэрийн алхаа
 - D. Биеийн жинг нэг хөлөөс нөгөө хөл рүү шилжүүлэх
 - E. Хөл газраас өргөгдөж өсгий газар тавигдах
1. Тавхайн inversion булчин хүчтэй агшиж, биеийн жин тавхайн гадна хэсэгт илүү нөлөөлнө
 2. Тавхайн eversion булчин хүчтэй агшиж, 2 өвдөг ойртсон байдлаар явдаг
 3. Түнхний ойртуулагч булчин чангарсан үед хөл солбиж алхана
 4. Дэлхийн татах хүчний төв цэг 4-5 см шилжилт хийнэ
 5. Аарцаг урагш 40 хэм эргэлт хийдэг

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A2 B3 C4 D5 E1
- C. A3 B4 C5 D1 E2
- D. A4 B5 C1 D2 E3
- E. A5 B1 C2 D3 E4

/50./ Үений контрактур үүссэн өвчтөнд доорх дасгалаас алийг хийх нь үр дүнтэй вэ?

- A. Хүчний дасгал
- B. Сунгалтын дасгал
- C. Далайцын дасгал
- D. Изотоник дасгал
- E. Изомерик дасгал

/51./ Чадаж буй ADL гэж юу вэ?

- A. Тухайн хүн (өвчтөн)яг хийж чадаж буй ADL
- B. Субъектив чадвар
- C. Суух, босох
- D. Өөртөө үйлчлэх чадвар
- E. Шатаар өгсөх, уруудах

/52./ Булчингийн агшилт тэмтрэгдэхгүй бол булчингийн хүчийг үнэлэх тестийн хэддүгээр балл вэ?

- A. 0
- B. 1
- C. 2
- D. 3
- E. 4

/53./ Дараах хэсгүүдийн тэмтрэхэд хийгдэх цэг, хөдөлгөөнийг уялдуулна уу?

- A. Цээжний 2-р нугамал 1
- B. Цээжний 7-р нугалам 2
- C. Хэвлийн гадна ташуу булчин 3
- D. Шууны артерий 4
- E. Дунд чөмөгний их төвгөр 5

1. Зүүн баруун далны дээд өнцгийг холбосон шугамтай огтлолцоно.

2. Зүүн баруун далны доод өнцгийг холбосон шугамтай огтлолцоно.

3. Дээш харж хэвтсэн байрлалд мөр холдуулах хөдөлгөөн хийлгэж, цээжийг нугалах, эргүүлэх хөдөлгөөн хийлгэнэ.

4. Шуу талын дистал хэсэгт байрлана.

5. Түнхний үеэн дээр тэмтэрч, хөлийг гадагш дотогш эргүүлэхэд тэмтрэгдэнэ.

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A2 B3 C4 D5 E1
- C. A3 B4 C5 D1 E2
- D. A4 B5 C1 D2 E4
- E. A5 B1 C2 D3 E4

/54./ Захын судсан дахь хүчилтөрөгчийн (SpO2) хэвийн агууламжийн хэмжээг сонгоно уу

- A. 90%
- B. 91%
- C. 98%
- D. 100%
- E. 96%

/55./ Дараах рефлексүүд хэдэн сартайгаас алга болох вэ?

- A. Моро рефлекс
- B. Атгах рефлекс
- C. Ландау рефлекс
- D. Бабинский рефлекс
- E. ATNR

- 1. 4-6 сартайд
- 2. 1-2 сартайд

- 3. 24-30 сартайд
- 4. 24 сартайд
- 5. 4-6 сартайд
 - A. A1 B2 C3 D4 E5
 - B. A5 B1 C2 D3 E4
 - C. C1 D2 E3 A4 B5
 - D. D1 E2 A3 B4 C5
 - E. E1 A2 B3 C4 D5

/56./ Гажиг засал гэж юувэ?

- A. Хөдөлгөөн хязгаарлах хэрэгсэл
- B. Ихэвчлэн мэс заслын дараа, хөдөлгөөнөөс сэргийлэх зорилготой хэрэгсэл
- C. Хэвийн бус байдлыг засах хэрэгсэл
- D. Туслах хэрэгсэл
- E. Цус тогтоох хэрэгсэл

/57./ ICF-ийн ангиллаар идэвхи гэж юуг хэлэх вэ?

- A. Хувь хүний зорилгот үйлийн гүйцэтгэл
- B. Аливаа үйлдлийг гүйцэтгэхэд гарах бэрхшээл
- C. Амьдарч буй орчны нөхцөл байдал
- D. Нийгмийн харилцаанд оролцоход гарах бэрхшээл
- E. Оролцооны идэвхи

/58./ Нэмэх цэнэгтэй эмийн бодис аль нь вэ?

- A. Адреналин
- B. Аскорбины хүчил
- C. Баралгин
- D. Гистамин
- E. Глутамины хүчил

/59./ Олонулсын үйл ажиллагааны ангилал (ICF)-аар булчингийн хүч (Manual Muscule testing)-3, мөрний үений нугалах хөдөлгөөний далайц хязгаарлагдах гэсэн ухагдахуун ямар ангилалд хамаарах вэ?

- A. Бие махбодийн эрхтэн тогтолцооны үйл ажиллагаа
- B. Бие махбодийн бүтэц, эрхтэн тогтолцоо, мөчид
- C. Бие махбодийн бүтэц, эрхтэн тогтолцоо, мөчдийн үйл ажиллагааны алдагдал
- D. Хувь хүний хүсэл зорилгоор хийгдэж буй үйл ажиллагаа
- E. Нийгмийн үйл ажиллагаанд оролцож буй оролцоо

/60./ Олон улсын үйл ажиллагааны чадвар алдалтын ангилал хэдэн онд ямар нэртэй болж шинэчлэгдсэн вэ?

- A. 2001 онд ICP
- B. 2002 онд ICIDH
- C. 2003 онд ICF
- D. 2004 онд ICIDH
- E. 2005 онд ICF

/61./ Хэт сунгалтыг нэрлэнэ үү?

- A. Үений эргэн тойрны булчин зөөлөн эд богиносож, хөдөлгөөн хязгаарлагдах
- B. Бие махбодийн үйл ажиллагааг сайжруулахын тулд тодорхой булчинг сонгож суллах
- C. Үений эргэн тойрны зөөлөн эдийг хэвийн хэмжээнээс илүү сунгах
- D. Гадны хүний оролцоогүйгээр өөрөө сунгах
- E. Тухайн үеэр хөдөлгөөн хийхэд саадгүй чөлөөтэй болох

/62./ Өвчтөн дасгал хийдэггүй бол ICF-р аль ангилалд хамруулах вэ?

- A. Идэвхи оролцоо
- B. Үйл ажиллагаа болон бүтэц
- C. Хувь хүний хүчин зүйл
- D. Орчны нөлөөлөл
- E. Үйл ажиллагаа

/63./ Нүдэнд үзэгдэх гэрлийн долгионы урт хэдэн н/м байдаг вэ?

- A. 700-420 н/м

- B. 720-400 н/м
- C. 730-700 н/м
- D. 740-420 н/м
- E. 760-400 н/м

/64./ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг нэрлэнэ үү?

A. Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгч, нийгэм болон өөр хоорондоо харилцахад баримтлах зарчмыг

B. Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдвөл зохих ёс зүйн тогтсон журмыг баримтлахыг

C. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахтай холбоотой бусадтай харилцах харилцааг

D. Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч, нийгэмтэй болон өөр хоорондоо харилцах харилцаа

E. Эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх дүрэм журам

/65./ Хэвтээ байрлалд шууг супинаци хийсэн байрлалд тохойн үеэр 45 градус нугалах нь булчингийн хүчийг шалгах тестийн хэддүгээр баллын тест вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

/66./ Дараах физик эмчилгээний төрлүүдийг тохируулна уу?

A. Цахилгаан эмчилгээ 1

B. Импульсийн эмчилгээ 3

C. Хувьсах гүйдлийн эмчилгээ 5

D. Цахилгаан соронзон талыайн эмчилгээ 2

E. Гэрэл эмчилгээ 4

1. Амплипульс эмчилгээ

2. УВЧ

3. Нил улаан гэрлийн эмчилгээ

4. Электорофорез эмчилгээ

5. Диадинамик эмчилгээ

A. A1 B2 C3 D4 E5

B. A2 B3 C4 D5 E1

C. A3 B3 C4 D5 E1

D. A4 B5 C1 D2 E3

E. A5 B1 C2 D3 E4

/67./ Бартелийн үнэлгээний бие даасан чадвартай байх нь хэдэн оноо байх вэ?

A. 50-аас дээш

B. 60-аас дээш

C. 70-аас дээш

D. 80-аас дээш

E. 85-аас дээш

/68./ Хөдөлгөөнийг гүйцэтгэхийг оролдох агшинд булчингийн агшилт тэмтрэгдэх төдий мэдрэгдэх нь булчингийн хүчийг үнэлэх тестийн хэддүгээр балл вэ?

A. 0

B. 1

C. 2

D. 3

E. 4

/69./ 45 настай эмэгтэй. Биеийн жин 55кг. Хурц үеийн Зүрхний шигдээсийн дараах сэргэлтийн үед сэргээн засах эмчилгээнд ирж байна. Энэ үйлчлүүлэгчид аль дасгалыг зөвлөх вэ?

A. Амьсгалын дасгал/дасгалтай/

B. Теннис тоглох

C. Алхалт хийх

D. Агаарын теннис тоглох

- Е. Шогшин гүйх
- /70./ Систолийн даралт гэдэг нь дараах тодорхойлолтуудас аль нь вэ?
- А. Судсаар урсан өнгөрөх цусны даралт
 - В. Цусны эзэлхүүний хурд ба захын судасны эсэргүүцлээр тодорхойлогдоно.
 - С. Зүрхний булчингийн агшилтын үед судасны хананд үзүүлэх даралт
 - Д. Зүрхний булчингийн сулралын үед судасны хананд үзүүлэх даралт
 - Е. Нэгж хугацаанд зүрхний агшилтаар аорт уруу шахагдах цусны даралт
- /71./ Зохицолт хөдөлгөөний үйл ажиллагааны утгыг уялдуулна уу?
- А. Хөдөлгөөний баримжаа алдагдах
 - В. Хөдөлгөөн сарних
 - С. Булчингийн хамааралт хөдөлгөөн алдагдах
 - Д. Тэнцвэр
 - Е. Эсрэг хөдөлгөөнийг давтах чадвар алдах
1. Зориудын хөдөлгөөнийг зорьсон газраа зогсоож чадахгүй байх
 2. Хөдөлгөөний алдагдалтай өвчтөнд хөдөлгөөний задрал бий болох
 3. Өдөр тутмын үйл хөдлөлийн хөдөлгөөний дараалал зохицол алдагдах
 4. Бие махбодийн байрлал, биеийн чанар, тогтвортой шинжээр биеийг хадгалж барьж байх чадварыг хэлнэ.
 5. Нэг мөч эсвэл биеийн хэг хэсэг, ээлжлэх хөдөлгөөнийг хийж чадахгүй байхыг хэлнэ.
- А. А1 В2 С3 D4 E5
 - В. А2 В3 С4 D5 E1
 - С. А3 В4 С5 D1 E2
 - Д. А4 В5 С1 D2 E3
 - Е. А5 В1 С2 D3 E4
- /72./ FIM үнэлгээний бие засахыг хянах бүлэгт хамаарагдах зүйлийг тодорхойлно уу?
- А. 00 хүртэл алхааг хянах
 - В. 00-д орж хувцас тайлахыг хянах
 - С. Шээс, 00-ийн суултуурыг хянах
 - Д. Шээс, өтгөнөө хянах
 - Е. 00-руу шилжих хөдөлгөөнийг хянах
- /73./ Шатаар өгсөж буухад бэрхшээл үүсэхийг ICF-н аль бүрэлдэхүүн хэсэгт хамааруулан авч үзэх вэ?
- А. Хувь хүний хүчин зүйл
 - В. Идэвхи оролцоо
 - С. Бүтэц үйл ажиллагаа
 - Д. Орчны хүчин зүйл
 - Е. Нийгмийн хүчин зүйл
- /74./ Электростимуляци эмчилгээнд ямар төрлийн гүйдлийн хэлбэрийг хэрэглэдэг вэ?
- А. Тэгш өнцөгт хэлбэрийн гүйдэл
 - В. Гурвалжин буюу гурван өнцөгт гүйдэл
 - С. Экспоненциал гүйдэл
 - Д. Тетаник хэлбэрийн гүйдэл
 - Е. Дөрвөлжин хэлбэрт гүйдэл
- /75./ Орны ирмэгээс урагш их биеийг гаргаж, доош харж хэвтсэн байрлалаас их биеэр өргөөд барьж чадаж байгаа учраас нурууны тэнийлгэх булчингийн хүч нь 3 балттай байна.
- /76./ Изомерик дасгалын үед амьсгал түгжигдэх хандлагатай учир артерийн даралт ихэсдэг. Иймээс зүрх болон тархины судасны эмгэгтэй хүнд изомерик дасгал эсрэг заалттай.
- /77./ Амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа нь өглөө орноос боссон цагаас орой орондоо ороод унтах хооронд хийж байгаа бүхий л үйл ажиллагаа учраас орноос босох, хооллох, нүүрээ угаах, хувцас өмсөх зэрэг үйлдэл нь энэхүү ухагдахуунд хамаарах юм.

/78./ Дээш харж хэвтсэн байрлалд тохойн үеэр нугалах хөдөлгөөнийг идэвхигүй аргаар хийлгээд хоёр толгойт булчинг тэмтрэхэд булчингийн агшилт тэмтрэгдэж байгаа учраас тохой нугалах булчингийн хүч 2 балттай байна

/79./ Хөдөлгөөний зохицуулга нь хувь хүн, хувь хүний зорилтот үйл, гадаад орчны харилцан үйлчлэлийн дүнд явагддаг учраас энэ нь мэдрэхүй, үйл хөдлөл, танин мэдэхүй гэсэн үйл явцтай байдаг.

/80./ Булчинг маш хурдтай сунгаснаар нугасны альфа мотонейроныг цочроож, булчингийн хүчдэлийг нэмэгдүүлнэ. Учир нь булчингийн хүчдэл ихсэхийг саатуулснаар эдийн сунах чадварыг сайжруулдаг.

/81./ Цахилгаан эмчилгээ нь хөдөлгөөний зохицуулгыг сайжруулдаг учраас мэдрэл булчингийн үйл ажиллагааны хямралыг сэргээдэг.

/82./ Цээж бүсэлхийн нурууны коббын өнцөг нь нурууны нугаламын их биеийн дээд ирмэг, доод ирмэгийг дайруулсан шугамын огтлолцолын хооронд үүсдэг өнцөг учраас коббын өнцгийг гагцхүү рентген зурган дээр тодорхойлох боломжтой

/83./ Суугаа байрлалд мөрний үеэр 90 градус нугалсан байрлалаас тохойн үеэр нугалах хөдөлгөөнийг идэвхигүй аргаар хийж чадаж байгаа учраас тохой нугалах булчингийн хүч 2 баллтай байна

/84./ Зогсоо байрлалд сагитал хавтгай далны маяа (акромион) өвдөгний том төвгөртэй огтлолцдог учраас шагай нь нэг шугамд огтлолцоно.

/85./ Олон улсын үйл ажиллагааны ангиллын нэгдүгээр бүлэгт бие махбодийн бүтэц, үйл ажиллагаа, үйл ажиллагааны багтаамж, гүйцэтгэл зэрэг ойлголт багтдаг учир нь энэхүү ангилалд орчны хүчин зүйл, хувь хүний хүчин зүйлийг багтаадаг.

/86./ Цусны урсгал, лимфийн урсгал, уургийн нөхөн төлжилтөд цахилгаан эмчилгээ үр дүнтэй учраас архаг болон цочмог хаван буулгахад ашигладаг.

/87./ Хажуугийн хавтгайд хүн цэх зогсож байх чихний гадна ирмэг, далны акромион сэртэн, дунд чөмөгний их төвгөр, өвдөгний үений урд хэсгээс 4-6 см нь нэг шугамд байрладаг учраас биеийн хүндийн төвийн шугам гэж нэрлэдэг.

/88./ Амьдралын чанар нь хувь хүн аж төрөх явцад итгэл найдвар, зорилго, амьдралын хэмжүүр, сонирхол зэргээс хамааран өөрийн амьдралын нөхцөл байдалд үнэ цэнэ өгөх учраас энэхүү ойлголт нь сэргэн засахын туйлын зорилго болдог.

/89./ Хөдөлгөөнд дадалших нь хөдөлгөөний өөрчлөлт, хөдөлгөөнийг эзэмших үйл явцыг судалдаг учраас ямарваа нэгэн шалтгааны улмаас үүссэн хөдөлгөөний алдагдал, дахин суралцах, хөдөлгөөний сэргэлтийн үйл явцыг авч үздэг

/90./ Цахилгаан эмчилгээ нь богиноссон зөөлөн эдийг сунгадаггүй учраас далайц сэргээхэд үр дүнгүй юм.

/91./ С8 мэдрэлийн түвшингийн миотомыг сонгоно уу?

1. Чигчий хуруу холдуулагч булчин
2. Эрхий хуруу тэнийлгэгч булчин
3. Эрхий хуруу ойртуулагч булчин
4. Урд шүдэт булчин
5. Хойд шүдэт булчин

/92./ Өгзөгний дунд булчингийн (gluteus medius) эхлэл төгсгөлийн цэгүүдийг сонгоно уу

1. Өгзөгний доод шугам
 2. Өгзөгний хойд болон урд шугамны хооронд (gluteal lines)
 3. Бага эргүүлэг
 4. Их эргүүлэг (greater trochanter)
 5. Дунд чөмөгний гадна ёрвон
- /93./ Их биеийн эмгэг төрх байдлыг сонгоно уу?
1. Сколиоз
 2. Кифоз ихсэх
 3. Лордоз ихсэх
 4. Аарцаг урагш хазайх
 5. Аарцаг арагш хазайх
- /94./ M. Gluteus medius булчингийн эхлэл болон төгсгөлийг сонгоно уу?
1. Ташаа ясны гадна доод гадаргуу
 2. Ташаа ясны гадна гадаргуу
 3. Дунд чөмөгний том төвгөрийн өмнөд хажуу ирмэг
 4. Дунд чөмөгний том төвгөрийн гадна тал
 5. Дунд чөмөгний дээд 1/3
- /95./ Өвдөгний хаалттай байрлалын төрхийг сонгоно уу?
1. Дунд чөмгөөр гадагш эргэсэн
 2. Өвдгөөр бүрэн тэнийсэн
 3. Шилбэ ясаар дотогш эргэсэн
 4. Шилбэ ясаар гадагш эргэсэн
 5. Тавхайгаар ээтийсэн
- /96./ Дээд мөчний PNF дасгалын хөдөлгөөний хэлбэрийг тодорхойлно уу?
1. Нугалах – ойртуулах – гадагш эргүүлэх
 2. Тэнийлгэх – холдуулах – дотогш эргүүлэх
 3. Нугалах – холдуулах – гадагш эргүүлэх
 4. Тэнийлгэх – ойртуулах – дотогш эргүүлэх
 5. Нугалах – холдуулах – дотогш эргүүлэх
- /97./ C2 мэдрэлийн түвшингийн дерматомыг сонгоно уу?
1. Чамархай
 2. Дух
 3. Дагз
 4. Хүзүү
 5. Мөр
- /98./ Нүүрний (frontal plane) хавтгай нь биеийг ямар хэсэгт хуваах вэ?
1. Дээд
 2. Урд
 3. Доод
 4. Өмнөд
 5. Баруун
- /99./ Мөрний үеэр нугалах хөдөлгөөн аль хавтгайд хийгдэх вэ?
1. Горизонтал хавтгай
 2. Фронтал хавтгай
 3. Фронт-Сагтал хавтгай
 4. Сагитал хавтгай
 5. Фронт- Горизонтал хавтгай
- /100./ Хөхний том (pectoralis major) булчингийн синергист булчингуудыг сонгоно уу?
1. Далбаа бучлин (latissimus dorsi)
 2. Далны хуудас булчин (Subscapularis)
 3. Том бөөрөнхий булчин (Teres major)
 4. Жижиг бөөрөнхий булчин (Teres minor)
 5. Хонин сүүлт булчин (Deltoid)
- /101./ Бүсэлхийн нурууны хэвтээ хавтгайд хийгдэж болох хөдөлгөөнийг сонгоно уу?
1. Баруун тал руу хазайх

2. Баруун тал руу эргэх
 3. Зүүн тал руу хазайх
 4. Зүүн тал руу эргэх
 5. Дарагдал
- /102./ Атаксик алхааны хэв маягийг сонгоно уу?
1. Түнхээр нугалсан
 2. Тогтвортой бус
 3. Тулах талбай бага (base of support)
 4. Тулах талбай өргөн
 5. Тавхайгаар жийсэн
- /103./ Өвдөгний урд хэсгийн өвдөлтөд хамаарах ухагдахуунуудыг сонгоно уу?
1. Тойгны мөгөөрс гэмтэх
 2. Шалтгаан тодорхойгүй байх
 3. Өсвөр насныханд илүү тохиолдох
 4. Эмэгтэйчүүдэд ихээр тохиолдох
 5. Дунд чөмөг, шилбэ ясны хооронд үүсэх үений зай буурах
- /104./ Дээд мөчний тэнийлгэх хэлбэрийн синергитик хөдөлгөөнийг сонгоно уу?
1. Дал унжсан
 2. Протракц хийгдсэн
 3. Мөрөөр дотогш эргэсэн
 4. Тохойгоор тэнийсэн
 5. Эрхий хуруугаар ойртуулсан
- /105./ Хайч хэлбэрийн алхаа үүсэх шалтгааныг сонгоно уу.
1. Тархины цус харвалт
 2. Ойртуулагч бучингийн чангарал
 3. Тархины саа
 4. Холдуулагч булчингийн сулрал
 5. Нугалагч булчингийн чангарал
- /106./ . Сколиоз-д хамаарагдах ухагдахуунуудыг сонгоно уу?
1. Лордоз ихсэх
 2. Гипоз ихсэх
 3. Булчингийн хүч унах
 4. Амьсгалын үйл ажиллагаа буурах
 5. Байрлал алдагдах
- /107./ Үсээ самнахад ямар хөдөлгөөнүүд оролцох вэ?
1. Бугуй тэнийлгэх, нугалах
 2. Шуу пронаци
 3. Тохой нугалах
 4. Мөр нугалах, гадагш эргүүлэх
 5. Мөр холдуулах
- /108./ 4-5 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?
1. Суухаар өөрөө өндийх
 2. Дээш харсан байрлалаас хажуу тийш эргэж харах
 3. Ухарч мөлхөх
 4. Юмнаас түшиж зогсох
 5. Нэг гар дээр тулж тоглоомруугаа хүрэх
- /109./ 1 МЕТ гэж юу вэ? Тодорхойлолтыг олно уу.
1. 1 минутанд 1 кг биеийн жинд 3.8 мл хүчилтөрөгч зарцуулагдана
 2. 1 минутанд 1 кг биеийн жинд 3.5 мл хүчилтөрөгч зарцуулагдана
 3. 1 минутанд кг биеийн жинд 3.5 мл хүчилтөрөгч зарцуулагдахгүй бөгөөдтухайн хүний бие махбодиос хамаарна
 4. Зүрхний эмгэгийн үед зарцуулагдах хүчилтөрөгчийн хэмжээ
 5. Зүрх судасны эмгэгийн үед зарцууагдах нүүрс – усны хэмжээ
- /110./ 10-11 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?
1. Ухрах болон хажуу тийш алхах

2. Богино хугацаанд бусдын дэмжлэггүйгээр зогсох
 3. Бусдын дэмжлэггүйгээр алхах
 4. Алган дээр тулж мөлхөх
 5. Суугаа байрлалаас бөмбөг шидэх
- /111./ 2 толгойт булчингийн эхлэл төгсгөлийн цэгүүдийг сонгоно уу.
1. Далны тогооны дээд хэсэг
 2. Эвэр хошуу сэртэн (coracoids process)
 3. Шуу ясны төвгөр (tuberosity of radius)
 4. Далны тогооны доод
 5. Богтос яс (ulna)
- /112./ Биемахбодын тогтвортой байдалд нөлөөлөх хүчин зүйлийг сонгоно уу?
1. Тулах талбайн өргөн
 2. Тулах талбай, хүндийн төвийн хамаарал
 3. Хүндийн төвийн өндөр
 4. Гаднаас үйлчлэх хүч
 5. Сэтгэл санаа
- /113./ Хажуугийн (sagittal plane) хавтгай нь биеийг ямар хэсэгт хуваах вэ?
1. дээд
 2. баруун
 3. доод
 4. зүүн
 5. урд, өмнөд
- /114./ Теннис тохойн үрэвслийн үед дараах шинжүүд илрэнэ?
1. Гар тэнийлгэгч булчингийн шөрмөсөнд үрэвсэл үүсэх
 2. Тохойн гадна ёрвонд дегенератив өөрчлөлт үүсэх
 3. Ямар нэгэн зүйлийг атгахад бэрхшээлтэй байх
 4. Шууны хүч буурах
 5. Бугуйгаар тэнийлгэгч булчинд жижиг хэмжээний урагдал үүсэх
- /115./ Үений далайцын тасралтгүй хийгдэх идэвхигүй дасгалыг (continuous passive motion; CPM) хийх зорилгуудаас бурууг нь тодорхойлно уу.
1. Үений хөшингө үүсэхээс сэргийлэх
 2. Үений далайцыг нэмэгдүүлэх
 3. Цусны эргэлтийг сайжруулах
 4. Булчингийн хүчийг сайжруулах
 5. Үений мөгөөрсийн өөрчлөлтөөс сэргийлэх
- /116./ M. Sartorius –ын эхлэл болон төгсгөлийг сонгоно уу?
1. Ууц яс
 2. Аарцаг ясны өмнөд дээд сэртэн (ASIS)
 3. Өвдөгний үений капсул
 4. Шаант ясны дотор дээд гадаргуу
 5. Дунд чөмөгний гадна төвгөр
- /117./ Урагш тонгойн бөхийхөд гравитацийн үйлчлэл мөн урагш шилжих бөгөөд энэ үед ямар хариу үйлдэл илрэх вэ?
1. Тавхай жийх
 2. Түнхний үеэр нугалах
 3. Өвдөгний үеэр тэнийлгэх
 4. Тавхай ээтийлгэх
 5. Шилбэний урд булчин чангарах
- /118./ Хөхний том (pectoralis major) булчингийн үүргийг сонгоно уу?
1. Мөрний үеэр горизонтал нугалах
 2. Мөрний үеэр ойртуулах
 3. Бугалга ясны дотогш эргэлт
 4. Мөрний үеэр холдуулах
 5. Мөрний үеэр тэнийлгэх
- /119./ Дээд мөчний нугалах хэлбэрийн синергитик хөдөлгөөнийг сонгоно уу?

1. Дал өргөгдсөн
 2. Дал ретракц хийгдсэн
 3. Тохой нугалсан
 4. Бугуй нугалсан
 5. Шуугаар супинаци хийгдсэн
- /120./ Өгзөгний дунд, жижиг булчингийн (gluteus medius and minimus) хүчний сулралын үед үүсэх нөлөөллийг сонгоно уу.
1. Түнхний үеэр холдуулах хүч буурна
 2. Алхааны үед хөл өргөгдсөн талын аарцаг унах
 3. Унах эрсдэл ихсэх
 4. Трендленбургийн шинж илрэх
 5. Алхааны урт богиносно
- /121./ C5 мэдрэлийн түвшингийн миотомыг сонгоно уу?
1. Далны хамрын дээд булчин
 2. Далны хамрын доод булчин
 3. Хонин сүүлт булчин
 4. 2 толгойт булчин
 5. 5. 3 толгойт булчин
- /122./ Далны маяа эгэмний хаалттай байрлалыг сонгоно уу?
1. Нугалах
 2. Холдуулах
 3. Гадагш эргүүлэх
 4. 90 градус хүртэл ходуулах
 5. 40 градус хүртэл тэнийлгэх
- /123./ Өгзөгний дунд (Gluteus medius) булчингийн сулралын үед илрэх алхааг нэрлэнэ үү?
1. Тааз эсрэг тал руугаа хазайх /trendelenburg's sign/
 2. Толгой их биеийг өвчтэй талдаа хазайж алхах /булчингийн дистрофи/
 3. Их биеийг зүүн баруун тийш хаяж алхах, гуйвах алхаа /wadding gait/
 4. Шувуун алхаа /steppage gait/
 5. Өсгийдөх алхаа
- /124./ Бүсэлхийн нурууны хажуугийн хавтгайд хийгдэх хөдөлгөөнийг сонгоно уу?
1. Баруун тал руу хазайх (right flexion)
 2. Урагш тонгойх (flexion)
 3. Эргүүлэх (rotation)
 4. Арагш гэдийх (extension)
 5. Зүүн тал руу хазайх (left flexion)
- /125./ Фибромиалгия-д хамаарах ухагдахуунуудыг сонгоно?
1. Үений бус шалтгаантай байх
 2. Булчингийн үрэвсэлтэй холбоотой байх
 3. Эмэгтэйчүүдэд илүү тохиолдох
 4. Эрэгтэйчүүдэд илүү тохиолдох
 5. Холбоосын үрэвсэлээс шалтгаалах
- /126./ 8-9 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?
1. Мөлхөх
 2. Суугаа байрлалаас доош харах
 3. Юмнаас түшиж зогсох
 4. Бусдын тусламжгүйгээр зогсох
 5. Алган дээр тулж мөлхөх
- /127./ Урд шүдэт (serratus anterior) булчингийн үүргийг сонгоно уу.
1. Далыг холдуулах
 2. Далны гадагш эргэлт (upward rotation)
 3. Дал өргөгдөх
 4. Далыг ойртуулах
 5. Далны дотогш эргэлт (downward rotation)
- /128./ Доод мөчний тэнийлгэх хэлбэрийн синергитик хөдөлгөөнийг сонгоно уу?

1. Түнх тэнийлгэсэн
2. Түнхээр дотогш эргэсэн
3. Түнхээр ойртуулах
4. Тавхайгаар жийсэн
5. Өвдгөөр тэнийсэн

/129./ Хэвтээ (horizontal plane) хавтгай нь биеийг ямар хэсэгт хуваах вэ?

1. Баруун
2. Дээд
3. Зүүн
4. Доод
5. урд, өмнөд

/130./ Цус харвалтын дараагаар ихэвчлэн үүсдэг тойрог алхааны хэв маяг аль нь вэ?

1. Хөл агаарт хөөрөх шатанд үүсдэг
2. Түнхний нугалах хөдөлгөөн буурдаг
3. Өвдөгний нугалах хөдөлгөөн буурдаг
4. Тавхайн ээтийлгэх хөдөлгөөн буурдаг
5. Түнхний тэнийлгэх хөдөлгөөн буурдаг

/131./ Остеоартритын үеийн шинжүүдийг сонгоно уу?

1. Үений мөгөөрсийг гэмтээнэ
2. Ихэвчлэн рентген зургийн тусламжтайгаар оношлогддог
3. Эмэгтэйчүүдэд илүүтэйгээр тохиолдоно
4. Эрэгтэйчүүдэд илүүтэйгээр тохиолдоно
5. Синовиал мембран гэмтэнэ

/132./ Нүүрээ угаах, арчихад ямар хөдөлгөөнүүд оролцох вэ?

1. Бугуй тэнийлгэх
2. Шуу супинаци
3. Тохой нугалах
4. Мөр нугалах
5. Мөр холдуулах

/133./ 2-3 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?

1. Доош харсан байрлалаас цээжийг өргөх
2. Доош харсан байрлалаас дээш эргэж харах
3. Дээш харсан байрлалд ATNR рефлекс үүсэх
4. Дээш харсан байрлалаас хөлийг жийх
5. Дээш харсан байрлалаас хажуу талруу эргэх

/134./ Хүндийн төв гэдэг нь юу вэ?

1. Байж болох бүхий л чиглэлд чөлөөтэй хөдлөх цэг
2. Биеийн хэсгүүд хүндийн хэмжээ харилцан тэнцвэртэй байх цэг
3. Үндсэн 3 тэнхлэгийн огтлолцох цэг
4. Зогсоо байрлалын үед бүсэлхий нурууны L5 ууцны S1 завсар орших цэг
5. Тодорхойлогдох боломжгүй цэг

/135./ Нээлттэй кинетик гинжний зарчимд хамаарагдах ухагдахуунуудыг сонгоно уу?

1. Проксимал сегментийн хөдөлгөөн
2. Дистал сегментийн хөдөлгөөн
3. Дистал сегментийн хөдөлгөөн хязгаарлалт
4. Бөмбөг өшиглөх нь нээлттэй кинетик гинжний зарчим
5. Бөмбөг өшиглөх нь хаалттай кинетик гинжний зарчим

/136./ 2-с дээш насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?

1. 3 дугуйтай унадаг дугуй унах
2. Ухарч алхах
3. Шатаар уруудах
4. Бөмбөг шидэх
5. Гүйх

/137./ Шаант ясны хугаралын дараах богиносох эрсдэлтэй булчин аль нь вэ?

1. Anterior tibial

2. Posterior tibialis muscle
 3. Long extensor digitorum muscle
 4. Long flexor digitorum muscle
 5. Extensor digitorum muscle
- /138./ С4 мэдрэлийн түвшингийн миотомыг сонгоно уу?
1. Хонин сүүлт булчин
 2. Трапец
 3. Далны доод хамрын булчин
 4. Дал өргөгч
 5. Цээжний жижиг булчин
- /139./ M. Rhomboid major –ын эхлэл болон төгсгөлийг сонгоно уу?
1. С7-Т1 нугалам
 2. Цээжний Т2-Т5 нугалам
 3. Нугаламын ирмэгээс дал хүртэл
 4. Далны доод өнцөг
 5. Бугалга ясны дотор төвгөр
- /140./ Мөрний үений хаалттай байрлалыг сонгоно уу?
1. Ойруулах
 2. Холдуулах
 3. Дотогш эргүүлэх
 4. Гадагш эргүүлэх
 5. Нугалах
- /141./ Хөхний жижиг (pectoralis minor) булчингийн эхлэл болон төгсгөлийг сонгоно уу.
1. 2-4-р хавирга
 2. 3-5-р хавирга
 3. Эгэм
 4. Эвэр хошуу сэртэн
 5. Бугалга яс
- /142./ Өгзөгний бага булчингийн (gluteus minimus) үүргийг нэрлэнэ үү.
1. Түнхний ойртуулах
 2. Түнхний холдуулах
 3. Түнхний гадагш эргүүлэх
 4. Түнхний дотогш эргүүлэх
 5. Түнхний тэнийлгэх
- /143./ 6-7 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?
1. Дээш харсан байрлалаас доош харах
 2. Нэг гар дээр тулж тоглоомруугаа хүрэх
 3. Ухарч мөлхөх
 4. Суугаа байрлалаас доош харах
 5. Мөлхөх
- /144./ Тахилзуурын урт (fibularis longus) булчингийн эхлэл төгсгөлийг сонгоно уу ?
1. Тахилзуурын проксимал хэсэг
 2. Тахилзуурын дистал хэсэг
 3. 4-р метатарзал
 4. 5-р метатарзал
 5. 3-р метатарзал
- /145./ Цамцны товч товчлоход ямар хөдөлгөөнүүд оролцох вэ?
1. Бугуй тэнийлгэх
 2. Шуу пронаци
 3. Тохой нугалах
 4. Мөр нугалах, холдуулах
 5. Тохой тэнийлгэх
- /146./ Трапец булчингийн дунд салааны хүчний сулралын улмаас үүсч болох нөлөөллийг сонгоно уу.
1. Далны ойртуулах хөдөлгөөн буурах

2. Далны ходуулах хөдөлгөөн хийгдсэн төрх байдал үүсэх
 3. Дал болон бугалганы булчингийн агшаалтанд бэрхшээл үүсгэх
 4. Бугалга ясыг далруу татах хүч буурах
 5. Далны холдуулах хөдөлгөөн буурах
- /147./ Алганы урт булчингийн (*Palmaris longus*) үүргийг нэрлэнэ үү?
1. Бугуйгаар тэнийлгэх
 2. Тохойгоор нугалах
 3. Мөрөөр нугалах
 4. Бугуйгаар нугалах
 5. Мөрөөр тэнийлгэх
- /148./ Доод мөчний нугалах хэлбэрийн синергитик хөдөлгөөнийг сонгоно уу?
1. Түнхээр холдуулсан
 2. Түнхээр гадагш эргүүлсэн
 3. Өвдгөөр нугалсан
 4. Хөлийн хуруугаар тэнийлгэсэн
 5. Шагайгаар жийсэн
- /149./ Давирах булчингийн (*Sartorius muscle*) үүргийг сонгоно уу.
1. Түнхээр нугалах
 2. Түнхээр гадагш эргүүлэх
 3. Түнхээр холдуулах
 4. Өвдөгний дотогш эргэлт
 5. Түнхээр дотогш эргүүлэх
- /150./ Ахиллын шөрмөсний урагдлын үед үүсэх шинжүүдийг сонгоно уу?
1. Өсгийн ясанд орох хэсгээс 1-2 инч
 2. 30-50 насны хүмүүст ихээр тохиолдоно
 3. Хөлийн хуруун дээр зогсож чадахгүй
 4. Томпсон тест (Thompson test) эерэг
 5. Трендленбург тест эерэг
- /151./ 1 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу ?
1. Физиологийн нугалах хөдөлгөөн
 2. Толгойг богино хугацаанд өргөх
 3. Зогсоход алхах рефлекс үүсэх
 4. Доош харсан байрлалаас цээжийг өргөх
 5. Суугаа байрлалаас толгойг цэхлэх
- /152./ *M. Quadratus lumborum* –ын эхлэл болон төгсгөлийг сонгон уу?
1. V-XII хавирга
 2. Ташаа ясны дотор ирмэг
 3. Ташаан ясны гадна ирмэг
 4. XII хавирганы доод ирмэг, бүсэлхийн L1-L4 хөндлөн сэртэн
 5. Дунд чөмөгний гадна төвгөр
- /153./ Эргүүлэгч булчингийн (*rotator cuff tendonitis*) үрэвсэлд хамаарагдах ухагдахуунуудыг сонгоно уу?
1. Далны дээд хамрын булчингийн сулрал үүснэ
 2. Далны дээд хамрын булчингийн сулралын улмаас бугалга ясны толгой далны тогоонд сайн шахагдахгүй
 3. Толгой дээгүүр гар өргөх идэвхи бүхий спортын үед уг булчин илүүтэйгээр гэмтэх шалтгаан болно
 4. 60-120 градусын мөрний холдуулах хөдөлгөөний үед ихэвчлэн өвдөлт үүснэ
 5. Өвчтөнд булчингийн хүч суларсан мэдрэмж үүснэ
- /154./ 16-24 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?
1. Шатаар өгсөх
 2. Шатаар уруудах
 3. Явган суух
 4. Бөмбөг өшиглөх
 5. Бөмбөг шидэх

/155./ Өгзөгний дунд булчингийн (gluteus medius) мэдрэлжүүлэлтийг сонгоно уу.

1. L4
2. L5
3. S1
4. S2
5. L3

/156./ Хэвлийн гүний булчингуудыг тодорхойлно уу.

1. Rectus abdominus
2. Multifidus*
3. Oblicus externus
4. Transverses abdomen
5. Oblicus internus

/157./ C4 мэдрэлийн түвшингийн дерматомыг сонгоно уу?

1. Мөр
2. Эгэм
3. Далны дээд хэсэг
4. Хэвлий
5. Нуруу

/158./ Трендлебургийн үеийн онцлогийг сонгоно уу?

1. Өгзөгний дунд (gluteus medius) булчингийн хүч суларна*
2. Биеийг хажуу тийш ихээр хазайлгана*
3. Биеийн жинг газарт байгаа хөл дээр төвлөрүүлэн шилжүүлнэ* (A)
4. Түнхээр нугалах хөдөлгөөн хийгдэнэ
5. Өвдөгний нугалах хөдөлгөөн хийгдэнэ

/159./ Шууны сарвууг нугалагч (flexor carpi radialis) булчингийн хатуурлын үед үүсэх хөдөлгөөний бууралтыг сонгоно уу.

1. Шуу ясруу (radius deviation) хазайх хазайлт буурах
2. Богтос ясруу (ulnar deviation) хазайх хазайлт буурах
3. Хуруу нугалах хөдөлгөөн буурах
4. Бугуйн тэнийлгэх хөдөлгөөн буурах
5. Бугуйн нугалах хөдөлгөөн буурах

/160./ Трапец булчингийн дээд салааны хатуурлын (tightness) улмаас үүсэх нөлөөллийг сонгоно уу

1. Мөр өргөгдөх
2. Далны гадагш эргэлт (upward rotation)
3. Хүзүүний үений далайц хязгаарлагдах
4. Мөр унжих
5. Далны дотогш эргэлт (downward rotation)

/161./ Дээд мөчний нугалах хэлбэрийн синергитик ямар үед үүсэх вэ?

1. Мөрөөр нугалах
2. Гарыг дээш өргөх
3. Тохойгоор тэнийлгэх
4. Гарыг сунгах
5. Мөрөөр холдуулах

/162./ Мөрний үе нь аль тэнхлэгт хөдөлгөөн гүйцэтгэх вэ?

1. Сагитал
2. Фроталь
3. Горизонтал
4. Нэг тэнхлэгт
5. 2 тэнхлэгт

/163./ Хүүхдийн цочих рефлексийн (startle reflex) үеийн шинжүүдийг сонгон уу?

1. Моро рефлекс тэй ижил
2. Стимуляцийн үед тохойн үеэр нугалсан хэвээр үлддэг
3. Ургийн хөгжлийн 28 долоо хоногтойгоос 5 сар хүртэл хугацаанд хариу урвал үүснэ
4. Цочих үед мөрний үеэр нугална

5. Цочих үед тавхайгаар жийх хөдөлгөөн хийгдэнэ
- /164./ Алчуур мушгихад ямар хөдөлгөөнүүд оролцох вэ?
1. Бугуй тэнийлгэх, нугалах
 2. Шуу пронаци, супинаци
 3. Тохой нугалах
 4. Мөр нугалах
 5. Мөр тэнийлгэх
- /165./ Түнхний үений хаалттай байрлалыг сонгоно уу?
1. Түнхээр бүтэн тэнийсэн
 2. Түнхээр дотогш эргэсэн
 3. Түнхээр холдуулах хөдөлгөөн хийгдсэн
 4. Түнхээр ойртуулах хөдөлгөөн хийгдсэн
 5. Өвдгөөр тэнийлгэсэн
- /166./ Алганы урт булчингийн (*Palmaris longus*) синергист булчингуудыг сонгоно уу
1. 3 толгойт булчин (*triceps*)
 2. Шууны сарвууг нугалагч булчин (*flexor carpi radialis*)
 3. Хурууг тэнийлгэгч булчин (*extensor digitorum*)
 4. Хурууг нугалагч булчин (*flexor digitorum superficialis*)
 5. 2 толгойт булчин (*biceps brachii*)
- /167./ Q өнцгийг хэмжихэд ямар цэгүүдийг ашиглах вэ?
1. . Тойгны төв болон шагайн гадна хашлага
 2. Таршааны урд дээд хамар
 3. Шагайн дотно хашлага
 4. Тойгны төв болон шилбэ ясны төвгөр
 5. Ташааны урд доод хамар
- /168./ 12-15 сар хүртэлх насны хүүхдийн хөгжлийн мөчлөгийг сонгоно уу?
1. Бусдын дэмжлэггүй алхах
 2. Ухарч алхах
 3. Хажуу тийш алхах
 4. Шатаар өгсөх
 5. Шатаар уруудах
- /169./ Доод мөчний PNF дасгалын хөдөлгөөний хэлбэрийг тодорхойлно уу?
1. Нугалах – ойртуулах – гадагш эргүүлэх
 2. Тэнийлгэх – холдуулах – дотогш эргүүлэх
 3. Нугалах – холдуулах – дотогш эргүүлэх
 4. Тэнийлгэх – ойртуулах – гадагш эргүүлэх
 5. Тэнийлгэх – холдуулах – гадагш эргүүлэх
- /170./ *M. iliocostalis thoracis* –ын эхлэл болон төгсгөлийг сонгоно уу?
1. VI хавирга I хавирганы өнцөг, C7 нугалам
 2. XII хавирга, VII хавирганы өнцөг
 3. XI хавирга, VI хавирганы өнцөг
 4. VI хавирга I хавирганы өнцөг, C7 нугалам
 5. X хавирга, I хавирганы өнцөг, C7 нугалам
- /171./ Паркинсоны алхааны хэв маягийг сонгоно уу?
1. Их биеэр урагш бөхийлт ихсэнэ
 2. Өвдгөөр нугалах хөдөлгөөн ихсэнэ
 3. Хурдан удаан алхаа холилдох
 4. Удаан алхаа
 5. Хурдан алхаа
- /172./ Төрөлхийн хүзүүний муруйлтанд хамаарагдах ухагдахуунуудыг сонгоно уу?
1. Булчингийн зориудын бус агшилт
 2. Хөхлөг сэртэн болон эгэм, өвчүүг холбосон булчингийн агшилт
 3. Толгой булчин татагдсан талруу нугалах
 4. Эрүү татагдсан булчингийн эсрэг талруу
 5. Далны дээд хамрын булчин агших

/173./ Бөхийж шалнаас юм авахад ямар хөдөлгөөнүүд оролцох вэ?

1. Түнх нугалах
2. Түнх холдуулах
3. Түнх гадагш эргүүлэх
4. Өвдөг нугалах
5. Тавхай ээтийлгэх

/174./ С3 мэдрэлийн түвшингийн дерматомыг сонгоно уу?

1. Хонин сүүлт булчин
2. Хүзүү
3. Мөр
4. Чамархай
5. Цээж

/175./ Өвдөгний урд хэсгийн өвдөлт нь тойг дунд чөмөгний хооронд өвдөлт үүсэх учраас 4 толгойт, түнхний булчингийн хүч суларсантай шууд холбоотой байдаг.

/176./ Суугаад цээжээр урагш тонгойх үед цээжний тэнийлгэгч булчингууд уртсан агших учраас их биеийг нугалагч булчингууд богиносон агшина.

/177./ Шилбэний урд булчингийн хүч суларсан учраас өвдөг нугалж чадахгүй, хэт тэнийж алхана.

/178./ Жижиг бөөрөнхий булчингийн (teres minor) хатуурлын үед мөрний үеэр дотогш эргүүлэх хөдөлгөөний далайц буурах учраас жижиг бөөрөнхий булчингийн (teres minor) төгсгөл нь бугалга ясны том төвгөр орчмоос бэхлэгддэг.

/179./ Өрцний амьсгалын дасгал нь амьсгал гаргах болон авах үед өрцний хөдөлгөөнийг сайжруулах учраас өвчтөний доминант гарыг хэвлийн урт булчин дээр байрлуулдаг.

/180./ Урд чагтан холбоос нь шилбэ ясны урагш шилжилтийг хязгаарладаг учраас өвдөгний урд чагтан холбоосын урагдлыг урагш татах шургуулаганы шинжээр илрүүлнэ.

/181./ Дал 30 хэмийн гадагш эргэх хөдөлгөөн хийхэд, бугалга ясаар 600-н холдуулах хөдөлгөөн хийх учраас дал бугалга ясны хэмнэл нь 1:2 гэсэн харьцаатай байдаг.

/182./ Тохойн үеэр 90 хэм нугалахад m.biceps brachii агших учраас антогност булчин M. triceps brachii суларна

/183./ Душейны алхаа нь өгзөгний дунд булчин (gluteus medius)-ийн хүч суларсан учраас тавхай бүтэн тавигдах (loading response) үед тааз тэр талдаа хаялна.

/184./ Том бөөрөнхий булчингийн (teres major) сулралын үед мөрний тэнийлгэх хөдөлгөөний хүч буурах хандлагатай учраас бөөрөнхий булчингийн (teres major) эхлэл нь далны доод өнцөг орчмоос бэхлэгддэг.

/185./ Синергитик хөдөлгөөн нь мэдрэлийн эмгэгийн үед үүсэх учраас дээд мөчний нугалах хэлбэрийн синергитик хөдөлгөөний үед мөрөөр ойртуулах хөдөлгөөн хийгддэг.

/186./ Хэвтээ байрлалаас хөлийг өргөхөд m.Rectus femoris агших учраас M.quadriceps агшиж, аарцаг эргэж хөл өргөдөг

/187./ Түнхний остеоартритын улмаас түнхний холдуулагч булчингийн хүч сулрах учраас аарцагны урагш эргэх хөдөлгөөн хийгддэг

/188./ Алхааны үед 4 толгойт булчингийн хүчний сулралын үед өвдгөөр нугалах учраас өвдөг тэнийлгэгч булчингийн хүчийг ихээр шаарддаг

/189./ Бугуйн үеэр тэнийлгэх хөдөлгөөн хийхэд m.Extensor radialis агших учраас гарыг атгаж суллахад m.flexor radialis агшдаг.

/190./ Өгзөгний том булчин (gluteus maximus)-ийн хүч суларсан учраас өсгий тавигдахад их бие, тааз арагшаа, түнхний үеэр нугарахаас зайлсхийж тэнийсэн байдлаар алхана

/191./ Аливаа эмгэгийн үед булчингийн хүчний дасгалыг изометрик хэлбэрийн дасгалаар эхлэх учраас изометрик дасгалын үед булчингийн урт өөрчлөгддөг.

/192./ Трендленбургийн алхаа нь өгзөгний дунд булчин (gluteus medius)-ийн хүч суларсан учраас тавхай бүтэн тавигдах (loading response) үед тааз эсрэг талдаа хялна.

/193./ Хүзүүгээр зүүн тийш эргүүлэх хөдөлгөөн хийхэд баруун талын m.sternocleidomastoid агших учраас баруун тийш эргүүлэхэд баруун талын m.sternocleidomastoid агшихгүй.

/194./ 2 болон 3 толгойт булчингийн хүч суларсан учраас 2 гар хоёр тийш хаялана.

/195./ Дөрвөн толгойт булчингийн хүч суларсан учраас их биеийг хоёр тийш хаялж алхана.

/196./ Удаан хугацаагаар ухаангүй байх, мөн булчингийн саажилтын (spastic) улмаас үүсэх яс ургалтаас (heterotopic ossification) сэргийлэх үр дүнтэй дасгалыг дурьдана уу?

- A. Үений далайцын идэвхитэй дасгал
- B. Үений далайцын идэвхигүй дасгал
- C. Булчингийн идэвхитэй агшилтын дасгал
- D. Булчингийн идэвхигүй агшилтын дасгал
- E. Сунгалтын дасгал

/197./ Зүрх судасны эмгэгтэй өвчтөний үеийн ачаалалтай сорилыг тохируулна уу?

1. 6 минутын туршид алхуулж, зүрх судас, амьсгалын үйл ажиллагааны чадварыг тогтоох сорил
 2. Хүчилтөрөгчийн шингээлтийн дээд хэмжээг хэмжих сорил
 3. Хүчилтөрөгчийн максимум зарцуулалтыг тооцох сорил
 4. Оношлогооны зорилгоор, ЭКГ-тэй давхар гүйцэтгэнэ
 5. 2,4 км-ийн зайд богино хугацаанд ачаалал өгч алхуулах сорил
- A. Алхааны сорил
 - B. Дугуй эргометрийн сорил
 - C. Гүйлтийн замын сорил
 - D. Шаттай сорил
 - E. 12 минутын алхааны сорил
- A. A1 B2 C3 D4 E5
 - B. A1 C2 D3 B4 E5
 - C. A1 D2 B3 C4 E5
 - D. A1 E2 D3 C4 B5
 - E. A1 B2 D3 C4 E5

/198./ Америкийн зүрхний холбооны эрсдэлт хүчин зүйлийн В-ангилалд орох шалгуурыг сонгоно уу?

- A. Эрэгтэй ≥ 45 , эмэгтэй ≥ 55 настай байх, зүрх судасны эрсдэлт 2 том хүчин зүйл болон түүнээс дээш байх
- B. Электрокардиограмм болон цусны даралтанд өөрчлөлтгүй байх
- C. Өвчний түүхэндээ ангин, ST сегмент цахилгаан сөрөг шугамаас доошлох
- D. Титэм судасны эмгэгүүд (миокардын шигдээс, титэм судасны цүлхэнгийн мэс засал хийлгэсэн байх, ангина...г.м.)
- E. Зүрхний хавхлагын эмгэг (зүрхний хавхлагын хүнд нарийсал үүнд хамаарахгүй)

/199./ Дөрвөлсөн саа тархи, нугасны аль гэмтлийн үед ихэвчлэн тохиолддог вэ?

- A. Тархины багана хэсгийн доод хэсэг, хүзүүний 6-р үеийн гэмтэл
 - B. Тархины багана хэсэг, нугасны хүзүүний дээд хэсэг
 - C. Тархины зүүн тал бөмбөлгийн гэмтэл
 - D. Тархины багана хэсгийн гэмтэл
 - E. Нугасны хүзүүний дээд хэсэг
- /200./ Зүрхний булчингийн хүчилтөрөгчийн зарцуулалтыг нэрлэнэ үү?
- A. Дасгалын үед булчингийн энергийн зарцуулалт нэмэгддэг
 - B. Зүрхний булчингийн хүчилтөрөгч зарцуулах чадвар
 - C. Дасгалын дүнд биемахбодид үзүүлэх нөлөөний босгыг даван мэдэгдэхүйц өөрчлөлт гарах шинж
 - D. Биемахбодийн ядрахгүйгээр удаан ажиллах чадвар
 - E. 1 минутанд 1 кг биеийн жингийн зарцуулж буй хүчилтөрөгчийн хэмжээ
58. Аеробик чанарыг нэрлэнэ үү?
- /201./ Багана нурууны нугасны гэмтлийн түвшин ,булчингийн хүчийг сайжруулах дасгалтай харилцан хамааралгүйг сонгоно уу.
- A. L1 _____ Аарцаг дээшлүүлэх
 - B. L2 _____ Түнх нугалагч булчин
 - C. L3 _____ Түнх холдуулагч булчин
 - D. L4 _____ Өвдөг тэнийлгэгч булчин
 - E. L5 _____ Өвдөг нугалагч булчин
- /202./ Хөдөлгөөний идэвхийн эрчмийг илэрхийлэх нэгжийг сонгоно уу?
- A. Метаболик эквивалент (МЭТ)
 - B. Метаболик индекс
 - C. Урвуу метаболик
 - D. Метаболиз
 - E. Мета эквивалент
- /203./ Цусны даралт ихсэх өвчтэй үйлчлүүлэгчийн дасгалт хөтөлбөрийн жорыг тодорхойлно уу?
- A. Аеробик төрлийн, дунд эрчимтэй дасгалыг өдөрт 30-60 минут, 8-12 удаагийн давталттай хийнэ
 - B. Аеробик төрлийн дасгалыг өндөр эрчмээр өдөрт 30 минут, долоо хоногт 3-5 удаа хийнэ
 - C. Эсэргүүцэлтэй дасгалыг 8-12 удаагийн дамтамжтай, өдөрт 30 минут хийнэ
 - D. Бага эрчимтэй, эсэргүүцэлтэй дасгалыг, нэг удаад 30 минутаар хийнэ
 - E. Дунд эрчимтэй, аеробик төрлийн дасгалыг өдөрт 15-30 минутаар хийнэ
- /204./ Түнхний остеоартритын үед илрэх төрх байдлыг сонгоно уу.
- A. Аарцгийн урагш эргэлт(anterior pelvic tilt)
 - B. Аарцгийн хойш эргэлт(posterior pelvic tilt)
 - C. Түнхний үеэр тэнийлгэсэн
 - D. Түнхний үеэр гадагш эргэсэн
 - E. Түнхний үеэр холдуулсан
- /205./ Харгалзах хөдөлгөөний нэр томъёонд уялдуулна уу?
1. Хэвтээ хавтгайд дээш харж хэвтсэн байрлалд цээжээр өндийх хөдөлгөөн
 2. Хэвтээ хавгайд доош харж хэвтсэн байрлалд цээжээр өндийх хөдөлгөөн
 3. Хажуугийн хавтгайд суугаа байрлалд мөрний үеэр гараа биеийн эсрэг талд хүргэх хөдөлгөөн
 4. Хажуугийн хавтгайд суугаа байрлалд мөрний үеэр гар алдлах хөдөлгөөн
 5. Нүүрний хавтгайд суугаа байрлалд шагайн үеэр тавхай доош, дотогшлуулах хөдөлгөөн
- A. Нугалах(flexion)
 - B. Тэнийлгэх(extension)
 - C. Холдуулах(abduction)
 - D. Ойртуулах(adduction)
 - E. Хазайх (inversion)
- A. A1 B2 C3 D4 A5
 - B. A1 B2 D3 C4 E5

C. B1 D2 C3 A4 E5

D. D1 C2 A3 E4 B5

E. E1 D2 C3 B4 E5

/206./ Америкийн зүрхний холбооны эрсдэлт хүчин зүйлийн А-ангилалд орох шалгуурыг сонгоно уу?

A. Эрэгтэй ≥ 45 , эмэгтэй ≥ 55 настай байх, зүрх судасны эрсдэлт 2 том хүчин зүйл болон түүнээс бага байх

B. Зүрхний хавхлагын эмгэг (зүрхний хавхлагын хүнд нарийсал хамаарахгүй)

C. хний булчингийн эмгэгт

D. Титэм судасны эмгэг

E. Титэм судасны цүлхэн

/207./ Америкийн нуруу нугасны гэмтлийн холбоо (ASIA)-ийн дасгалын үнэлгээнд нуруу нугасны түвшин болон гол булчинтай холбогдохдоо тохироогүй нь сонгоно уу?

A. C5 _____ Тохой нугалагч бүлэг булчин

B. C6 _____ Бугуй нугалагч бүлэг булчин

C. C7 _____ Тохой тэнийлгэгч бүлэг булчин

D. C8 _____ Хуруу тэнийлгэгч бүлэг булчин

E. T1 _____ Чигчий хуруу холдуулагч бүлэг булчин

/208./ Янз бүрийн дасгал, хөдөлгөөний үеийн биемахбодын хариу урвал, богино болон урт хугацааны дасан зохицол, зүй тогтлыг судлах шинжлэх ухааныг сонгоно уу

A. Дасгалын физиологи

B. Хөдөлгөөн судлал

C. Биомеханик

D. Дасгалын биохими

E. Биоэнерги

/209./ 7 настай хүүхдэд хэдэн хэвийн бус рефлекс байвал алхах тавилан муу гэж үзэх вэ?

A. 2 болон түүнээс дээш

B. 3 болон түүнээс дээш

C. 4 болон түүнээс дээш

D. 5 болон түүнээс дээш

E. 6 болон түүнээс дээш

/210./ Аарцаг нурууны ритм гэж юу вэ?

A. Өвдөг нугалахгүйгээр нуруу урагш тонгойход аарцаг урагш эргэх ба нуруу гэдийхэд аарцаг хэвэндээ орж, бүсэлхий нуруу дээш болно

B. Өвдөг нугалахгүйгээр нуруу урагш тонгойход аарцаг урагш эргэхгүй бөгөөд эргээд нуруу гэдийж хэвэндээ орно

C. Өвдөг нугаларч, нуруу урагш бөхийхэд аарцаг урагш эргэх ба нуруу гэдийхэд аарцаг хэвэндээ орж, бүсэлхий нуруу дээш болно

D. Өвдөг нугалахгүйгээр нуруу урагш тонгойход аарцаг урагш эргэх ба нуруу гэдийхэд аарцаг хэвэндээ орж, бүсэлхий нуруу дээш болно

E. Өвдөг нугалахгүйгээр аарцаг урагш эргэх нуруу бөхийж, эргээд нуруу гэдийхэд аарцаг хэвэндээ орж, бүсэлхий нуруу дээш болно

/211./ Цохилтын эзэлхүүн гэж юу вэ? нэрлэнэ үү

A. Зүрхний нэг цохилтонд гарч байгаа цусны хэмжээ

B. Хувь хүний ажиллах чадвар

C. асгалын эрчмээр тодорхойлогдоно

D. Ачаалал ихсэхэд буурдаг

E. VO₂ - ыг дагаж ихэсдэг

/212./ Чихрийн шижин хэв шинж 2 өвчтэй хүний дасгалт хөтөлбөрийн жорыг тодорхойлно уу.

A. 40-60 хувийн эрчимтэй, боргийн үнэлгээгээр 11-13, долоо хоногт минимум 150 минут дасгал хийх

B. 60-85 хувийн эрчимтэй, боргийн үнэлгээгээр 13-аас дээш, долоо хоногт 300 минут дасгал хийх

C. Өндөр эрчимтэй, боргийн үнэлгээгээр 11, долоо хоногт 150 минутаас доошгүй дасгал хийх

D. Бага эрчимтэй, боргийн үнэлгээгээр 11, долоо хоногт 3-5 удаа, 300 минутаас доошгүй дасгал хийх

E. Дунд эрчимтэй, долоо хоногт 5 удаа, 300 минутаас доошгүй дасгал хийх

/213./ Остеоартритын улмаас үений аль хэсэг илүүтэйгээр гэмтэх вэ?

- A. Үений холбоос
- B. Синовиал мембран
- C. Үений мөгөөрс
- D. Үеийг тойрсон булчин
- E. Яс

/214./ Өвдөгний үе солиулах хагалгааны дараах зөвлөмжийг тохируулна уу.

- 1. Өвдөгний үеэр ≥ 90 хөдөлгөх
- 2. 3 толгойт булчингийн хүчийг сайжруулах
- 3. Идэвхгүй аргаар өвдөг нугалах
- 4. Өвдөгний үеэр 100-105 хэм хүртэл нугалах дасгал
- 5. Таяггүй алхах, өвдөгний үеэр 105-120 хэм хүртэл нугалах дасгал

- A. Хагалгааны дараах 2 долоо хоногт
- B. Хагалгааны өмнө
- C. Хагалгааны дараах 1-3 долоо хоногт
- D. Хагалгааны дараах 3-6 долоо хоногт
- E. Хагалгааны дараах 6-12 долоо хоногт

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A1 B2 D3 E4 C5
- C. A1 D2 B3 C4 E5
- D. A1 C2 D3 E4 B5
- E. A1 E2 B3 C4 D5

/215./ 1 сартай хүүхдэд ямар хэлбэрийн хөдөлгөөний доминант үүсэх вэ?

- A. Тэнийлгэх хэлбэрийн хөдөлгөөний доминант
- B. Нугалах хэлбэрийн хөдөлгөөний доминант
- C. Labyrinthine righting хөдөлгөөний рефлекс үүсэх
- D. Хүзүүний тогтвортой хөдөлгөөн
- E. Мөчдийн холдуулах хөдөлгөөний доминант

/216./ Амьсгалын эзлэхүүн гэж юу вэ?

- A. Амьсгал тайван аваад тайван гаргах эзлэхүүний хэмжээ
- B. Амьсгал дээд зэргээр гүнзгий гаргасны дараа уушгинд үлдэх агаарын хэмжээ
- C. Амьсгал гүнзгий авсан үед уушгинд байх агаарын хэмжээ
- D. Амьсгал тайван гаргасны дараа уушгинд үлдэх хэмжээ
- E. Амьсгал тайван гаргасны дараа дээд зэргээр гүнзгий амьсгал гаргах

/217./ Хөдөлгөөний идэвхийн эрчмийг тохируулна уу?

- 1. Энгийн хэмнэлээр алхах A. 2 MET
- 2. Ор хураах, аяга угаах B. 2.5 MET
- 3. Шогших C. 5.0 MET
- 4. Цонх угаах, машин угаах D. 8.0 MET
- 5. Хурдтай гүйх E. 3.0 MET

- A. A1 B2 C3 D4 E5
- B. A1 C2 D3 E4 B5
- C. A1 B2 C3 E4 D5
- D. E1 D2 C3 B4 A5
- E. B1 C2 A3 E4 D5

/218./ Цулцангийн агааржуулалт багасах, V/Q харьцаа их хэмжээгээр алдагдсанаас цусны CO_2 -ийн парциал даралт ≥ 44 мм.муб болоход HCO_3^-/PCO_2 багасч, Рн буурах үзэгдлийг сонгоно уу

- A. Хүчилшил
- B. Шүлтшил
- C. Амьсгалын ацидоз
- D. Амьсгалын алкалоз

- Е. Бодисын солилцооны алколоз
- /219./ Ясны сийрэгжилтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сонгоно уу?
- А. Биеийн хүндийн төвийг идэвхитэй болон идэвхигүй шилжүүлэх, булчингийн идэвхитэй агшилт хийх
- В. Булчингийн идэвхигүй далайцын дасгал, ясны сийрэгжилтээс сэргийлэх эм уух (яс хэлбэржүүлэх бэлдмэл, кальци болон Д витамин, эстроген орлуулагч гм...)
- С. Булчингийн идэвхитэй далайцын дасгал, биеийн хүндийн төвийг шилжүүлэх, ясны сийрэгжилтийн эсрэг эм уух
- Д. Биеийн хүндийн төвийг идэвхитэй болон идэвхигүй шилжүүлэх, булчингийн идэвхитэй агшилт хийх, ясны сийрэгжилтээс сэргийлэх эм уух
- Е. Биеийн хүндийн төвийг доод мөчинд төвлөрүүлэх идэвхигүй дасгал
- /220./ Зүрхний цус хомсролын үеийн сэргээн засах эмчилгээг тохируулна уу?
1. ЗШ-ийн эрт үеийн сэргээн засах тусламж үйлчилгээ
 2. Эмнэлгээс гарсны дараах сэргээн засах тусламж үйлчилгээ
 3. Эмнэлгээс гарснаас хойш 4-6 долоо хоног
 4. Сэргээн засахын тусламж үйлчилгээний дунд үе
 5. Сэргээн засахын урт хугацааны тусламж үйлчилгээ
- А. Цочмог үе буюу тасагт байх үе
- В. Тогтворжуулах үе
- С. Дасгал хийлгэх үе
- Д. Эдгэрэх үе буюу эмчилгээг гэрт нь үргэлжлүүлэн хийх үе
- Е. Гэрийн дасгалт хөтөлбөрт хамрагдах үе
- А. А1 В2 С3 D4 E5
- В. А1 D2 С3 E4 B5*
- С. А1 В2 В3 С4 E5
- Д. E1 D2 С3 B4 A5
- Е. В1 A2 С3 D4 E5
- /221./ “Ревматоидны кисть” гэж гарын ямар хэлбэрийг нэрлэх вэ?
- А. Бугуй тэнийлгэх хэлбэрийн контрактуртай болсноос гар нь чигчий хуруу тал руугаа хазайсан хэлбэрийн контрактур үүснэ
- В. Бугуй нугалах хэлбэрийн контрактуртай болсноос гар нь чигчий хуруу тал руугаа хазайсан хэлбэрийн контрактур үүснэ
- С. Тохой тэнийлгэх хэлбэрийн контрактуртай болсноос гар нь чигчий хуруу тал руугаа хазайсан хэлбэрийн контрактур үүснэ
- Д. Тохой нугалах хэлбэрийн контрактуртай болсноос гар нь чигчий хуруу тал руугаа хазайсан хэлбэрийн контрактур үүснэ
- Е. Гарыг чанга атгах үед хурууны урт нугалах булчингууд хуруу руу татдаг
- /222./ Дасан зохицох чадварын тодорхойлолтыг олно уу?
- А. Дасгалын үед булчингийн энергийн зарцуулалт нэмэгддэг
- В. Зүрхний булчингийн хүчилтөрөгч зарцуулах чадвар
- С. Дасгалын дүнд биемахбодид үзүүлэх нөлөөний босгыг даван мэдэгдэхүйц өөрчлөлт гарах шинж
- Д. Биемахбодийн ядрахгүйгээр удаан ажиллах чадвар
- Е. 1 минутанд 1 кг биеийн жингийн зарцуулж буй хүчилтөрөгчийн хэмжээ
- /223./ Мөч тайралтын дараах сэргээн засах эмчилгээний ач холбогдлыг нэрлэнэ үү.
- А. Үений хөдөлгөөнийг нэмэгдүүлж, контрактур үүсэхээс сэргийлэх
- В. Булчингийн ядралыг бууруулах
- С. 2 хөлийн булчингийн хүчийг тэнцүүлж, тэнцвэрийг бууруула
- Д. Тайрагдсан мөчний эргэн нөхөн төлжих явцыг түргэсгэх
- Е. Булчингийн хатингаршлыг нэмэгдүүл
- /224./ Дараах мэдрэлийн язгуурын гэмтлийн үед үүсэх хам шинжийг тохируулна уу.
1. С4 язгуурын гэмтэл
 2. С5 язгуурын гэмтэл
 3. С6 язгуурын гэмтэл
 4. С7 язгуурын гэмтэл

5. С8 язгуурын гэмтэл

A. Тохойн нугалах, дотогш эргүүлэх хүч суларна.

B. 2 толгойт булчингийн рефлекс бүдгэрнэ. Мөрний гадагш эргүүлэх хүч суларна.

C. 3 толгойт булчингийн рефлекс бүдгэрэн, бугалга, сарвуу, хурууг тэнийлгэх хүч буурна.

D. Хурууг нугалах, холдуулах хүч суларна.

E. Хүзүүний дээд хэсгээр өвдөлт өгнө.

A. 1A 2B 3C 4D 5E

B. 1A 2C 3D 4E 5B

C. 1E 2B 3A 4C 5D

D. 1E 2A 3C 4D 5B

E. 1B 2A 3C 4D 5E

/225./ Шатны рефлекс нь хэдийд дарангуйлагдах ёстой вэ?

A. 5 сартайд

B. 12 сартайд

C. 3 настайд

D. 5 настайд

E. 6 настайд

/226./ Ласегийн шинжийг тодорхойлно уу?

A. 2 хөлийг зэрэг дээш өргөхөд нурууны өвдөлт нэмэгдэнэ

B. Өвчтөнг зогсоож байгаад бөхийлгөн, гар шал 2 – ын хоорондын зайг үзнэ

C. Хөлийн хуруун дээр олон удаа босож суулгахад чадахгүй байх

D. Өсгийн дээр явуулахад явж чадахгүй

E. Өлмий дээр зогсоож байгаад огцом буулгах үед өвдөлт илэрнэ

/227./ Хүүхдийг доош харуулан хэвтүүлэхэд толгойг өргөх нь аль рефлексийн дүнд үүсэх вэ?

A. Moro рефлекс

B. STNR

C. Labyrinthine righting рефлекс

D. ATNR

E. Парашют

/228./ Зүрх судасны эмгэгтэй өвчтөнд дасгалаар хичээллэж байх үед ямар шинж илэрвэл зогсоох вэ?

A. Цээжээр өвдөх, тайван үеийн зүрхний минутын цохилт >100 цохилт/мин, <50 цохилт/мин, Сис-145мм Hg, диа- 95 мм Hg, шагайгаар хавагнах

B. Тайван үеийн зүрхний минутын цохилт >100 цохилт/мин, <50 цохилт/мин, Сис-145мм Hg, диа- 95 мм Hg, шагайгаар хавагнах

C. Цээжээр өвдөх, тайван үеийн зүрхний минутын цохилт >100 цохилт/мин, <50 цохилт/мин

D. Сис-145мм Hg, диа- 95 мм Hg

E. Цээжээр өвдөх, тайван үеийн зүрхний минутын цохилт >110 цохилт/мин, <50 цохилт/мин, Сис-150мм Hg, диа- 95 мм Hg, шагайгаар хавагнах

/229./ Уушгины амьдралын багтаамж гэж юу вэ?

A. Амьсгал хэвийн гаргасны дараа дээд зэргээр гүнзгий амьсгал авах

B. Амьсгал тайван гаргасны дараа уушгинд үлдэх хэмжээ

C. Амьсгал гүнзгий авсан үед уушгинд байх агаарын хэмжээ

D. Амьсгал дээд зэргээр гүнзгий аваад, дээд зэргээр гүнзгий гаргах үе

E. Амьсгал тайван аваад тайван гаргах

/230./ Хөдөлгөөний алдагдалд орж хэвтрийн дэглэмд шилжсэн үед хэдий хугацаанаас ясны сийрэгжилтийн процесс идэвхжиж эхэлдэг вэ?

A. Эхний 10цаг

B. Эхний 20цаг

C. Эхний 30цаг

D. Эхний 40цаг

E. Эхний 50цаг

/231./ Эрүүл 18-65 насны хүмүүсийн аэробик хөдөлгөөний идэвхийн тохирсон хэмжээг сонгоно уу?

- A. 7 хоногт 5 удаа хамгийн багадаа 30 минут хийх.
- B. 7 хоногт 3 удаа хамгийн багадаа 10 минут хийх.
- C. 7 хоногт 2 удаа хамгийн багадаа 10 минут хийх.
- D. 7 хоногт 5 удаа хамгийн багадаа 10 минут хийх
- E. 7 хоногт 3 удаа хамгийн багадаа 10 минут хийх.

/232./ Дараах булчингийн хүчний сулрал, саажилтын үед үүсэх эмгэг алхааг тохируулна уу.

1. Шаантны урд булчингийн хүч суларсан
 2. Өгзөгний дунд булчингийн хүч суларсан
 3. Өгзөгний том булчингийн хүч суларсан
 4. Шилбэний арын булчингийн хүч суларсан
 5. 4 толгойт булчингийн хүч суларсан
- A. Өлмий унжсан хэлбэрийн алхаа (drop foot gait)
 - B. Тренделенбург алхааны шинж
 - C. Өвдгөөр хэт их тэнийсэн алхаа
 - D. Өлмийгөөр түлхэлт хийгдэхгүй, улдсан алхаа (Flat foot gait)
 - E. Цээж арагш гэдийсэн хайвганасан алхаа (Extensor, gluteus maximus lurch gait)
- A. 1A 2C 3D 4B 5E
 - B. 1A 2B 3E 4D 5C
 - C. 1B 2A 3C 4D 5E
 - D. 1B 2C 3D 4A 5B
 - E. 1A 2B 3E 4C 5D

/233./ Тренделенбургийн шинж дараах эмгэгүүдээс аль эмгэгийн үед давамгайлсан тохиолдох вэ?

- A. Ревматоид артрит
- B. Түнхний остеоартрит
- C. Өвдөгний остеоартрит
- D. Шагайн үений остеоартрит
- E. Өвдөгний урт хэсгийн өвдөлт

/234./ Түнхний үе солиулах хагалгааны дараах зөвлөмжийг тохируулна уу.

1. Үений дистал хэсэгт далайц багатай дасгал хийж эхлэх
 2. Хагалгаа хийлгэсэн тал дээр хэвтэх боломжтой
 3. Түнхний үеэр 90 градусаас дээш нугалж, оймсоо өмсөх боломжтой
 4. Цана тэшүүрээр гулгах
 5. Гүйх болон үсрэх
- A. Хагалгаа хийлгэсний дараах эрт үе
 - B. Хагалгаа хийлгэсний дараах 6 долоо хоног
 - C. Хагалгаа хийлгэсний дараах 12 долоо хоног
 - D. Хийхгүй байхыг зөвлөх
 - E. Хийж болохгүй хөдөлгөөн
- A. A1 B2 C3 D4 E5
 - B. A1 B2 C3 E4 D5
 - C. A1 C2 D3 E4 B5
 - D. A1 D2 C3 B4 E5
 - E. A1 E2 C3 B4 D5

/235./ Остеоартритын үед илрэх үений хөшингийг яаж арилгах вэ?

- A. Бага идэвхтэй дасгалаар
- B. Өндөр идэвхтэй дасгалаар
- C. Изометрик дасгалаар
- D. Изотоник дасгалаар
- E. Изокинетик дасгалаар

/236./ Постурал дренаж гэж юу вэ?

- A. Жийргэвч ашиглан ханиалгуулах арга
- B. Уушгины янз бүрийн сегментэд хуримтлагдсан шүүрлийг өвчтөний байрлалыг өөрчлөх замаар гадагшлуулах арга
- C. Гуурсан хоолойноос шүүрлийг соруулж авах арга

- D. Тайвшруулах арга
 E. Өрцийг оролцуулан ханиалгуул
- /237./ Хүчилтөрөгчийн максимум зарцуулалтыг олно уу?
 A. Дасгалын үед булчингийн энергийн зарцуулалт нэмэгддэг
 B. Зүрхний булчингийн хүчилтөрөгч зарцуулах чадвар
 C. Дасгалын дүнд биемахбодид үзүүлэх нөлөөний босгыг даван мэдэгдэхүйц өөрчлөлт гарах шинж
 D. Биемахбодийн ядрахгүйгээр удаан ажиллах чадвар
 E. 1 минутанд 1 кг биеийн жингийн зарцуулж буй хүчилтөрөгчийн хэмжээ
- /238./ Зүрхний шигдээсийн дараах үйл ажиллагааны чадвар алдагдлын 2-р шатанд хөдөлгөөний ямар хязгаарлалт үүсэх вэ?
 A. Ердийн ачаалалд өөрчлөлт илрэхгүй
 B. Ямар ч үед зовиуртай
 C. Тайван үед хэвийн, ердийн ачаалалд бага зэрэг өөрчлөлт илэрнэ
 D. Зүрхний үйл ажиллагаа тогтворжих учир хязгаарлалт үүсэхгүй
 E. Хязгаарлалт хэвийн хэмжээнээс их байна
- /239./ Парашют хариу урвал нь хэдэн сартайд үүссэн байх ёстой вэ?
 A. 4 сартайд
 B. 6 сартайд
 C. 8 сартайд
 D. 12 сартайд
 E. 15 сартай
- /240./ Амьсгалын замын эмгэгийн үеийн хүчиллэг чанар ихсэлт гэж юу вэ?
 A. Уушигны цулцангийн агааржилт буурсанаас CO₂ хуримтлагдаж үүсдэг
 B. Уушигны агааржилт ихэссэнээс цусан дах Н⁺ буурч үүсдэг
 C. Бодисын солилцооны алдагдлаас HCO₃⁻ буурч, цусан дах Н⁺ ихэснэ
 D. Бодисын солилцооны алдагдлаас HCO₃⁻ буурч, цусан дах Н⁺ буурна
 E. Уушигны цуцангийн агааржилт ихэссэнээс CO₂ ихэснэ
- /241./ Labyrinthine рефлекс юуны үр дүнд үүсэх вэ?
 A. Биеийн байрлал солигдох
 B. Зогсоо үед
 C. Дээд мөчний хөдөлгөөний үед
 D. Доод мөчний хөдөлгөөний үед
 E. Их биеийн нугалах хөдөлгөөний үед
- /242./ Саажилт (paralysis) нь дээд мөчний ямар булчинд зонхилон тохиолддог вэ?
 A. Тэнийлгэгч (extension) бүлэг булчингууд
 B. Нугалагч (flexion) бүлэг булчингууд
 C. Нугалагч, тэнийлгэгч булчингууд
 D. Холдуулагч (abduction) булчингууд
 E. Ойртуулагч (adduction) булчингууд
- /243./ Нуруу нугасны гэмтлийн мэдрэлийн сүлжээний түвшинтэй мэдрэхүй бууралт нь зөв холбогдсон 2 зөв хариултыг сонгоно уу?
 A. T5 -----Хөхний толгойн хэсэгт мэдээ алдагдах
 B. T10-----Ахар сүүлний хэсэгт мэдээ алдагдах
 C. T12-----Хүйсний төв хэсэгт мэдээ алдагдах
 D. L2-----Цавиний хэсэгт мэдээ алдагдах
 E. S2-----Хярсангийн хэсэгт мэдээ алдагдах
- /244./ Цус харвалтын дараах суугаа байдлын булчингийн зохицуулгыг тохируулна уу?
 1. Цэх суусан байрлалаас арагш гэдийх
 2. Баруун тийш хазайсан байрлалаас цэх суух
 3. Цэх суусан байрлалаас аарцаг яс хөдлөхгүй цээжээр баруун тийш хазайх
 4. Цэх суусан байрлалаас урагш тонгойх
 5. Нуруу бөхийсөн байрлалаас цэх суух
 A. Нугалах булчингийн экцентрик агшилтаас изометрик агшилт руу шилжих
 B. Зүүн хажуугийн нугалах булчингийн концентрик агшилт

- C. Хазайсан талын булчин богиносож, зүүн хажуугийн нугалах булчин экцентрик агшилт
- D. Тэнийлгэх булчингийн экцентрик агшилт
- E. Тэнийлгэх булчингийн концентрик агшилт

- A. C1 D2 E3 A4 B5
- B. E1 D2 C3 B4 A5
- C. A1 B2 C3 D4 E5
- D. B1 C2 D3 A4 E5
- E. A1 B2 D3 E4 C5

/245./ Зүрхний цус хомсролын үеийн сэргээн засах эмчилгээг тохируулна уу?

1. ЗШ-ийн эрт үеийн сэргээн засах тусламж үйлчилгээ
 2. Эмнэлгээс гарсны дараах сэргээн засах тусламж үйлчилгээ
 3. Эмнэлгээс гарснаас хойш 4-6 долоо хоног
 4. Сэргээн засахын тусламж үйлчилгээний дунд үе
 5. Сэргээн засахын урт хугацааны тусламж үйлчилгээ
- A. Цочмог үе буюу тасагт байх үе
 - B. Тогтворжуулах үе
 - C. Дасгал хийлгэх үе
 - D. Эдгэрэх үе буюу эмчилгээг гэрт нь үргэлжлүүлэн хийх үе
 - E. Гэрийн дасгалт хөтөлбөрт хамрагдах үе
- A. A1 B2 C3 D4 E5
 - B. A1 D2 C3 E4 B5
 - C. A1 B2 B3 C4 E5
 - D. E1 D2 C3 B4 A5
 - E. B1 A2 C3 D4 E5

/246./ Нурууны өвдөлтийн үед дараах тестүүдийн алийг нь хэрэглэх вэ

- A. Томас
- B. Бабински
- C. См.Кера
- D. Ахиллын рефлекс
- E. ATNR

/247./ 75 настай эрэгтэй. Зам тээврийн осолд ороод хүзүүний 5 түвшний нугалам гэмтсний улмаас дөрвөн мөчний саа үүссэн. Гэмтэл аваад 6 сар болсон. Суух үедээ сандлын түшлэг ашигладаг ба энэ босоход нь дэмжлэг болдог. Хоол идэхдээ өргөн бариултай сэрээг ашиглаж биеэ даасан. Бие засах өрөө ашиглахад нь харгалзах хүн шаардлагатай. Хувцасаа тайлахдаа тусламж авдаг. Гэр дотроо шилжилт хөдөлгөөн хийхдээ түшлэгний бариул ашигладаг.

Америкийн нуруу нугасны гэмтлийн холбоо (American spinal injury association) үйл ажиллагааны алдагдалд L4 –ийн гол булчинг сонгоно уу?

- A. Iliopsoas muscle
- B. Gastrocnemius
- C. Anterior tibialis muscle
- D. Quadriceps femoris muscle
- E. Extensor pollicis longus muscle

/248./ Уушигны сегментийг тэлэх дасгалын зорилгыг тодорхойлно уу.

- A. Амьсгал авах үеийн уушигны багтаамжийг нэмэгдүүлнэ
- B. Амьсгал гаргалтыг хянах боломжийг олгоно
- C. Амьсгаадалтыг намжаана
- D. Уушигны гиповентиляцийн үед тухайн хэсгийг тэлж, амьсгалд оролцуулах
- E. Өрцний ядралыг багасгах

/249./ Ур чадварт суурилсан хөдөлгөөний идэвхийн бүрэлдэхүүнийг сонгоно уу?

- A. Авхаалж сайжруулах. Биемахбодын орон зай дахь нарийн нийлмэл үйлдэлийг өөрчлөх чадвар сайжрах
- B. Бие махбодын зохицол сайжрах (булчин, өөх, болон бусад биеийн хэсгүүдийн хэмжээ)
- C. Булчингийн хүч сайжрах.
- D. Булчингийн тэсвэр сайжрах.

- Е. Үений далайц сайжрах (уян хатан чанар)
- /250./ Зүрхний шигдээсийн үед ЭКГ – д ямар шинж илрэх вэ
- А. Т шүд илрэхгүй
 - В. Q шүд тод илэрнэ
 - С. STсегмент илрэхгүй
 - Д. QRS хэвийн байна
 - Е. Т шүд буурна
- /251./ Жирэмсэн үеийн дасгалын жорыг нэрлэнэ үү?
- А. Долоо хоногт 2 удаа 30 минут, өндөр эрчимтэй дасгал хийх
 - В. Долоо хоногт 3-4 удаа 15-30 минут дунд эрчимтэй дасгал хийх
 - С. Долоо хоногт 3-5 удаа 30 минут дунд эрчимтэй дасгал хийх
 - Д. Долоо хоногт 3 удаа 15 минут өндөр эрчимтэй дасгал хийх
 - Е. Долоо хоногт 5-6 удаа бага эрчимтэй дасгал хийх
- /252./ Эмфизем үүсэх шалтгааныг олно уу?
- А. Цулцангийн жигд агааржилт өөрчлөгдөн, вентиляци, перфузийн харьцаа алдагдсанаас
 - В. Гуурсан хоолойн үйл ажиллагаа алдагдсанаас
 - С. Их хэмжээний цэр салс хуримтлагдсанаас
 - Д. Уушгины уян хатан чанар алдагдсанаас
 - Е. Цулцангийн хөндийн дотоод даралт буурсанаас
- /253./ Цусанд агуулагдах H^+ ионы агууламж ихсэн ($pH < 7.35$), хүчил суурийн тэнцвэр алдагдах үзэгдлийг сонгоно уу
- А. Хүчилшил
 - В. Шүлтшил
 - С. Амьсгалын ацидоз
 - Д. Амьсгалын алкалоз
 - Е. Бодисын солилцооны алкалоз
- /254./ Биеийн жинг бууруулах дасгалын анхны гарааны эрчмийг сонгоно уу?
- А. Бага ачаалал (2-3МЭТ)
 - В. Дундаж ачаалал (3-4)
 - С. Дундаж ачаалал (3-4), их ачаалал (6<МЭТ)
 - Д. Их ачаалал (6<МЭТ)
 - Е. Бага ачаалалыг (2-3МЭТ) аажмаар 0.5-1.0МЭТ-р ахиулна
- /255./ Тэсвэрлэх чанарын тодорхойлолтыг олно уу ?
- А. Дасгалын үед булчингийн энергийн зарцуулалт нэмэгддэг
 - В. Зүрхний булчингийн хүчилтөрөгч зарцуулах чадвар
 - С. Дасгалын дүнд биемахбодид үзүүлэх нөлөөний босгыг даван мэдэгдэхүйц өөрчлөлт гарах шинж
 - Д. Биемахбодийн ядрахгүйгээр удаан ажиллах чадвар
 - Е. 1 минутанд 1 кг биеийн жингийн зарцуулж буй хүчилтөрөгчийн хэмжээ
- /256./ Парашютаар саажилттай хүүхдийг үнэлэхэд дээд мөчинд ямар хариу урвал үүсэх вэ?
- А. Зөвхөн эрүүл гараар шаланд хүрнэ
 - В. Зөвхөн саатай талын гараар шаланд хүрнэ
 - С. 2 гарны шалруу тэмүүлэх хөдөлгөөн дарангуйлагдана
 - Д. Эрүүл талын гарыг тохойн үезр нугална
 - Е. 2 гараар шаланд хүрнэ
- /257./ Labyrinthine righting рефлексийн үр дүнд аль булчингийн идэвх нэмэгдэх вэ?
- А. Нугалагч булчин
 - В. Ойртуулагч булчин
 - С. Тэнийлгэгч булчин
 - Д. Холдуулагч булчин
 - Е. Эргүүлэгч булчин
- /258./ Түнхний остеоартритын үед ихэвчлэн аль булчингийн хүч илүүтэйгээр алдагдах вэ?
- А. Түнхний ойртуулагч булчин
 - В. Түнхний холдуулагч
 - С. Түнхний нугалагч

D. Түнхний гадагш эргүүлэгч

E. Түнхний дотогш эргүүлэгч

/259./ Америкийн зүрх судас болон уушигны сэргээн засахын холбооны эрсдэлт хүчин зүйлийн ангиллын өндөр эрсдэлт хүчин зүйлд орох шалгуурыг сонгоно уу?

A. Дасгалын явцад ST сегмент цахилгаан сөрөг шугамаас 1 мм болон түүнээс бага хэмжээтэй доошлох (далд цусан хангамжийн дутагдал)

B. Дасгалын явцад ST сегмент цахилгаан сөрөг шугамаас 2-мм доошлох

C. Дасгалын явцад ST сегмент цахилгаан сөрөг шугамаас ≥ 2 мм доошлох

D. Биемахбод нь < 5 МЭТ –ээс бага ачаалал даах чадвартай байх

E. Дасгалын үеийн гемодинамик хэвийн байх

/260./ Ревматоид артритын шалтгааныг сонгоно уу.

A. Гэмтлийн дараах

B. Төрөлхийн

C. Дархлааны

D. Бактерийн

E. Халдварын

/261./ Цус харвалтын дараах буруу байрлалыг харгалзах эрүүл байрлалтай уялдуулна уу?

1. Биеийн жин хоёр сүүжний ясны төвгөр дээр тэнцүү хувиарлагдах

2. Хажуугийн хавтгайд нурууны физиологийн муруйлт

3. Цээжний хэнхэрцэг мөрний доогуур аарцагны дээгүүр тэгш хэмтэй байх

4. Хоёр мөрний өндөр ижил байх

5. Тавхай бүхий л талбайгаар шалтай харьцах, биеийн жин жигд хувиарлагдах

A. Биеийн жин жигд бус хувиарлагдах

B. Бүсэлхий лордоз багасах, цээжний кифоз ихсэх

C. Тэгш бус харьцаатай болох

D. Тэгш бус өндөртэй болох

E. Тавхайд очих биеийн жин жигд бус хувиарлагдах

A. A1 C2 D3 E4 B5

B. A1 B2 C3 D4 E5

C. E1 B2 A3 C4 D5

D. A1 B2 D3 C4 E5

E. B1 C2 D3 E4 A5

/262./ Америкийн зүрх судас болон уушигны сэргээн засахын холбооны эрсдэлт хүчин зүйлийн ангиллын дунд эрсдэлт хүчин зүйлд орох шалгуурыг сонгоно уу?

A. Дасгалын явцад ST сегмент цахилгаан сөрөг шугамаас 1 мм болон түүнээс бага хэмжээтэй доошлох (далд цусан хангамжийн дутагдал)

B. Ховдлын хэм алдагдал нь дасгалын явцад болон ачааллын дараах амралтын үед илрэхгүй байх

C. Зүрхний дутагдал

D. Тайван үеийн хэм алдагдал

E. Дасгалын явцад ST сегмент цахилгаан сөрөг шугамаас 2-мм доошлох

/263./ Бие махбодын 1 минутанд зарцуулах хүчилтөрөгчийн хамгийн дээд хэмжээг тодорхойлно уу

A. Хүчилтөрөгчийн хэрэглээ (VO_2 max)

B. MET

C. Анаэробик босго

D. Стенокардийн босго

E. Аэробик чадамж

/264./ Булчин, үений хоорондох холбогч эдийн богиносолт, үений далайцын алдагдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

A. Хүчийг сайжруулах, сунгалтын хөтөлбөрт дасгал зохиох

B. Сунгалтын дасгал хийлгэх, чиг барих

C. Тодорхой системтэй, үечилсэн сунгалтын дасгалыг урт хугацаагаар хийлгэх

D. 1 удаагийн сунгалтын дасгалыг 30 болон түүнээс дээш минутанд тодорхой системтэй, үечилсэн сунгалтын дасгалын хөтөлбөрөөр хийх

Е. 1 удаагийн хүчний дасгалыг 30 болон түүнээс дээш минутанд тодорхой системтэй, үечилсэн сунгалтын дасгалын хөтөлбөрөөр хийх

/265./ Дараах хөдөлгөөнийг харгалзах мэдрэлжүүлэлттэй уялдуулна уу?

1. Тавхай жийх
2. Тавхай ээтийлгэх, гадагш хазайлгах
3. Тавхай жийх, гадагш хазайлгах
4. Өвдөг тэнийлгэх
5. Өвдөг нугалах

A. L5-S2

B. Тахилзуурын гүний мэдрэл L4-S1

C. Тахилзуурын өнгөц мэдрэл L4-S1

D. Дунд чөмөгний мэдрэл L2-L4

E. Ууцны мэдрэл L5-S3

A. A1 B2 C3 E4 D5

B. A1 B2 C3 D4 E5

C. B1 C2 D3 A4 E5

D. B1 C2 D3 A4 E5

E. E1 D2 C3 B4 A5

/266./ Өвдөгний остеоартритын үеийн сунгалтын дасгалын эмчилгээний нотолгооны товшинг нэрлэнэ үү.

A. A1

B. C2*

C. B2

D. B1

E. A2

/267./ Протезын алхааны хүндрэл, шалтгааныг тохируулна уу.

1. Өсгий газар хүрэх (heel strike) фазын дараа өвдөгний нугалах хөдөлгөөн хязгаарлагдах

2. Stance фазын үед өвдөг хэт тэнийх

3. Өсгийг газраас хөндийрүүлэх фаз хязгаарлагдах

4. Шилбэ ясны урд хэсэгт ачаалал ирэх

5. Stance фазын төгсгөлд өлмий унжих

A. Өсгийн хэсэг хэт зөөлөн байх

B. Өсгий жийх хэлбэр давамгайлсан байх

C. Өсгий хэт хатуу байх

D. Өлмий хэт ээтийлгэх хэлбэртэй байх

E. Хөлний доод хэсэг хэт зөөлөн байх

A. A1 B2 C3 D4 E5

B. A1 B2 C3 E4 D5

C. A1 B2 E3 D4 C5

D. A1 C2 D3 E4 B5

E. A1 D2 E3 C4 B5

/268./ Эрүүл мэндэд суурилсан хөдөлгөөний идэвхийн бүрэлдэхүүнийг сонгоно уу?

A. Харааны болон сонсголын мэдрэхүйн үйлийг сайжруулсанаар нарийн үйл хөдлөлийг чадварлаг гүйцэтгэж, координацийг нэмэгдүүлэх

B. Хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй байх үеийн тэнцвэртэй байдлын хяналтыг идэвхжүүлэн тэнцвэрийг сайжруулах

C. Хөдөлгөөний үе дэх цусны эргэлт болон амьсгалын системийн хүчилтөрөгчийн хангамжийн чадварыг сайжруулах нь зүрх судасны эрхтэн тогтолцооны тэсвэржилтийг нэмэгдүүлэх

D. Дасгалын гүйцэтгэлийн хурдыг бага багаар нэмэгдүүлэх

E. Ажлыг гүйцэтгэх 1 удаагийн хүч болон тэсвэрийг сайжруулах

/269./ Зүрхний шигдээсийн үеийн дасгалт хөтөлбөрийг зогсоох заалтыг олно уу?

A. Тогтвортой хэлбэрийн зүрхний бах

B. Ачаалалтай сорил, дасгалын үеийн эмнэлзүйн шинжгүй

- C. Зүрхний хэм алдагдал үүсэх
- D. Боргийн үнэлгээгээр 11 оноотой
- E. Хүйтэн хөлс гарах

/270./ Дараах нугасны гэмтлийн дараах үйл ажиллагааны алдагдлыг тохируулна уу.

1. 3 толгойт булчин, хурууны нугалах, тэнийлгэх булчингийн үйл ажиллагаа хадгалагдана
2. Цээжний булчингийн хүч суларч, тэнцвэр муудна
3. Бугуйн тэнийлгэх хөдөлгөөн үлдэнэ. Ортезийн тусламжтай хуруугаа нугална.
4. Өвдөг-шагай-тавхайн ортезийн тусламжтай явах боломжтой
5. Deltoid, biceps булчингийн үйл ажиллагаа хэвийн учир мөрний хөдөлгөөн хадгалагдана.

- A. C5 түвшний гэмтэл
 - B. C6 түвшний гэмтэл
 - C. C7-T1 түвшний гэмтэл
 - D. T2-T5 түвшний гэмтэл
 - E. L1-L3 түвшний гэмтэл
- A. A1 B2 C3 D4 E5
 - B. C1 D2 B3 E4 A5*
 - C. C1 D2 A3 B4 E5
 - D. C1 A2 D3 E4 B5
 - E. A1 D2 B3 E4 C5

/271./ Гуурсан хоолойн архаг үрэвслийн үеийн сэргээн засах эмчилгээг олно уу?

- A. Бодисын солилцооны идэвхийг нэмэгдүүлэх
- B. Цусны эргэлтийг сайжруулах
- C. Үрэвслийг намдааж, сэдрэлтээс сэргийлж чийрэгжүүлэх
- D. Төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг сайжруулах
- E. Бие махбодийн идэвхийг нэмэгдүүлэх

/272./ Ревматоид артритын үед үений аль хэсэг илүүтэйгээр гэмтэх вэ?

- A. Үений холбоос
- B. Синовиал мембран
- C. Үений мөгөөрс
- D. Үеийг тойрсон булчин
- E. Яс

/273./ Цус харвалтын дараах сэргээн засах эмчилгээ хийгдээгүйн улмаас зонхилон ямар хөдөлгөөнд контрактур үүсдэг вэ?

- A. Нугалах (flexion)
- B. Тэнийлгэх (extension)
- C. Холдуулах (abduction)
- D. Гадагш эргүүлэх(external rotation)
- E. Тавхай ээтийлгэх (planter dorsiflexion)

/274./ Биеийн жингийн илүүдэлийг илэрхийлсэн утгыг олно уу?

- A. БЖИ \geq 15 кг•м²
- B. БЖИ \geq 15-20 кг•м²
- C. БЖИ \geq 20-24 кг•м²
- D. БЖИ \geq 25 кг•м²
- E. БЖИ \geq 30 кг•м²

/275./ Дээд мөчдийн тайралтын сэргээн засахын үе шатыг уялдуулна уу.

1. Ампутаци хийлгэхийн өмнөх зөвлөгөө A. 1-р үе
 2. Ампутаци хийлгэсний дараах хурц үе B. 2-р үе
 3. Протезийн өмнөх үеийн бэлтгэл C. 3-р үе
 4. Протез зүүх бэлтгэл, дасгал D. 4 –р үе
 5. Удаан хугацааны эмчилгээ E. 5-р үе
- A. A1 B2 D3 E4 C5
 - B. A1 B2 C3 D4 E5
 - C. A1 B2 C3 E4 D5
 - D. A1 B2 D3 C4 E5

Е. А1 С2 В3 Е4 D5

/276./ Хөдөлгөөний идэвхи гэж юу вэ?

А. Биемахбодын хөдөлгөөний үед араг ясны булчин энерги ашиглан агшиж сулраж буй идэвхитэй үйлийг хэлнэ.

В. Биемахбодын давтагдсан, системтэй, төлөвлөгдсөн үйлийг хэлнэ.

С. Биемахбодын хөдөлгөөнийг гүйцэтгэх чадварыг хэлнэ.

Д. Биемахбодын хөдөлгөөний ур чадвар, системтэй үйлийг хэлнэ.

Е. Биемахбодын хөдөлгөөний үед араг ясны булчин агших үйлийг хэлнэ.

/277./ Уушигны архаг бөглөрөлт өвчний үеийн дасгалт хөтөлбөрт оруулахгүй байх заалтыг олно уу?

А. Тахикарди

В. Тогтворгүй зүрхний бах

С. Архаг халдварт өвчин /ДОХ/

Д. Чихрийн шижин

Е. Тогтвортой зүрхний бах

/278./ Цус харвалтын дараах мөчдөд булчингийн тонус ихсэх хэлбэрийг тохируулна уу.

1. Арагш татагдсан, мөр доош унжсан А. Аарцаг

2. Аддукци үүссэн, дотогш эргэсэн В. Бугуй

3. Нугалсан хэлбэр, чигчий хуруу тийш хазайсан С. Тавхай

4. Арагш эргэж, саажсан тал дээш татагдсан D. Мөр

5. Унжсан хэлбэр, инверси үүссэн Е. Дал

А. А1 В2 С3 D4 E5

В. E1 D2 В3 A4 C5

С. E1 C2 В3 A4 D5

Д. A1 C2 D3 B4 E5

Е. E1 C2 В3 A4 D5

/279./ Дээд мөчний булчингийн чангарлыг арилгах зорилгоор ботулинум токсин хэрэглэх нь ямар булчинд хэрхэн үйлчлэх вэ?

1. Мөрний үеэр ойртуулах, дотогш эргүүлэх (subscapularis/pectoralis major)

2. Тохой нугалах (brachioradialis/biceps/brachialis)

3. Шуу пронаци хийх (pronator quadrates /pronator teres)

4. Бугуйн үеэр нугалах (flexor carpi radialis/brevis/ulnaris/extrinsic finger flexors)

5. Гар атрах (flexor digitorum profundus/sublimis)

А. Мөрний үеийн ойртуулах, дотогш эргүүлэх далайцыг нэмэгдүүлэх, мөрний өвдөлт, контрактур, чангарлыг багасгах

В. Өдөр тутмын үйл ажиллагаа (ADL), эрүүл ахуй, гоо сайхны үйл ажиллагааг сайжруулах

С. Гарын баримжаа нэмэгдүүлэх

Д. Өдөр тутмын үйл ажиллагаа (ADL) нэмэгдүүлэх, өвдөлт багасгах

Е. Эрүүл ахуйг сайжруулах

А. А1 В2 С3 D4 E5

В. А1 С2 D3 E4 B5

С. А1 В2 С3 E4 D5

Д. В1 С2 A3 E4 D5

Е. E1 C2 D3 A4 B5

/280./ 85. Хүчилтөрөгчийн оролцоогүйгээр энерги (АТФ) нийлэгжүүлэн биемахбодын энергийн хэрэгцээг хангах, 30 секундээс 3 минут хүртэлх хугацаанд өрнөх нөөцтэй урвалыг сонгоно уу

А. Фосфаген систем

В. Анаэробик систем

С. Аэробик систем

Д. Фосфолипидын задрал

Е. Липидын задрал

/281./ Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгааныг тодорхойлно уу?

А. Төрөлхийн

В. Удамшил

С. Хүйс

- D. Гэрийн нөхцөл
E. Ажлын таатай нөхцөл
- /282./ Зүрх судасны эмгэгтэй өвчтөн бага эрсдэлтэй үед ямар шинж тэмдэг илэрдэг вэ?
A. Зүрх судасны тогтолцооны эмгэг илэрнэ
B. Бодисын солилцооны эмгэгийг илтгэх шинжүүд илэрнэ
C. Шинж тэмдэг илрээгүй, зүрх судасны эрсдэл 1-тэй тэнцүү байх
D. Шинж тэмдэг илрээгүй, зүрх судасны эрсдэл 2 ба түүнээс дээш
E. Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг илэрнэ
- /283./ Мого рефлекс хэдэн сартайгаас эхлэн алга болох вэ?
A. 4 сартай
B. 5 сартай
C. 6 сартай
D. 7 сартай
E. 8 сартай
- /284./ Амьсгал авалтын багтаамж гэж юу вэ?
A. Амьсгал тайван гаргасны дараа уушгинд үлдэх хэмжээ
B. Амьсгал хэвийн гаргасны дараа дээд зэргээр гүнзгий амьсгал авах
C. Амьсгал гүнзгий авсан үед уушгинд байх агаарын хэмжээ
D. Амьсгал дээд зэргээр гүнзгий аваад, дээд зэргээр гүнзгий гаргах үе
E. Амьсгал тайван аваад тайван гаргах
- /285./ Америкийн зүрхний холбооны эрсдэлт хүчин зүйлийн D- ангилалд орох шалгуурыг сонгоно уу?
A. Хүнд хэлбэрийн хавхлагийн нарийсал
B. Биемахбод нь зөвхөн <6 МЭТ эрчимтэй дасгалыг гүйцэтгэх чадвартай байх
C. Электрокардиограмм болон цусны даралтанд өөрчлөлтгүй байх
D. Өвчний түүхэндээ ангин, ST сегмент цахилгаан сөрөг шугамаас доошлох
E. Титэм судасны эмгэгүүд (миокардын шигдээс, титэм судасны цүлхэнгийн мэс засал хийлгэсэн байх, ангина...г.м.)
- /286./ Спирометрийн үүргийг олно уу?
A. Зүрхний үйл ажиллагааг хянах үүрэгтэй
B. Амьсгалын замын эмгэгийн үед уушигны үйл ажиллагааг хянах
C. Хүчилтөрөгчийн хангамжийг үзэх
D. Өвчний сэдрэлийг хянах
E. Уушигны займжих хөдөлгөөнийг хянах
- /287./ Шинж тэмдгийн бус зүрх судасны эрсдэл бүхий чихрийн шижинтэй өвчтөний гараа хөдөлгөөн эмчилгээний эрчмийн заагийг сонгоно уу?
A. Бага эрчим
B. Бага эрчим→дунд эрчим
C. Бага эрчим→дунд эрчим→өндөр эрчим
D. Дунд эрчим
E. Дунд эрчим→бага эрчим
- /288./ 2.3 – 3.3 МЕТ нь биеийн хүчний ямар ажлын нөхцөлд зарцуулагдахыг олно уу?
A. Гэрийн хөнгөн ажил
B. Юм бичээд суух
C. Хувцас угаах
D. Хувцас өмсөж, тайлах
E. Үйлдвэрийн хөнгөн ажил
- /289./ Дараах нурууны өвдөлтийн дерматомын байрлалыг тохируулна уу.
1. Нуруу, дунд чөмөгний толгой, цавь орчим
2. Нуруу, гуяны урд талаар өвдөг хүртэл
3. Өгзөг, гуяны араар, шилбэ орчим
4. Нуруу, өгзөгний дээд хэсэг, гуяны урдуур, шилбэний дотор тал
5. Цавь, гуяны дотор талаар өвдөг хүртэл
A. L1
B. L2

C. L3

D. S1

E. S3

A. A1 B2 C3 D4 E5

B. A1 C2 B3 E4 D5

C. A1 B2 D3 C4 E5

D. A1 C2 D3 E4 B5

E. A1 B2 E3 D4 C5

/290./ Алхааны үед хөл өргөгдөх (midswing phase) үед түнхний үеэр хэдэн градусын нугалах хөдөлгөөн хийх вэ?

A. 10 хэм

B. 15 хэм

C. 20 хэм

D. 25 хэм

E. 30 хэм

/291./ Саажилт (paralysis) нь доод мөчний ямар булчинд зонхилон үүсдэг вэ?

A. Тэнийлгэгч (extension) бүлэг булчингууд

B. Нугалагч (flexion) бүлэг булчингууд

C. Нугалагч, тэнийлгэгч булчингууд

D. Холдуулагч (abduction) булчингууд

E. Ойртуулагч (adduction) булчингууд

/292./ Хэв шинжит бус зүрхний шигдээсийн эмнэлзүйн шинж тэмдгийг уялдуулна уу

1. Багтраат хэлбэр

2. Хэвлийн хэлбэр

3. Оворгын хэлбэр

4. Хэм алдалтын хэлбэр

5. Тархины хэлбэр

A. Амьсгаадах, бачуурах, цээж давчдах

B. Аюулхайд өвдөх, бөөлжих, бөөлжис цутгах

C. АД гэнэт буурах, ухаан алдах, муужрах

D. Пароксизмал тахикарди, шинэ хориг үүсэх

E. Тархинд цус харвах, толгой эргэх, ухаан самуурах

A. A1 B2 D3 C4 E5

B. A1 B2 C3 D4 E5

C. A1 B2 D3 C4 E5

D. A1 E2 D3 C4 B5

E. A1 D2 C3 B4 E5

/293./ Доод мөчний булчингийн чангарлыг арилгах зорилгоор ботулинум токсин хэрэглэх нь ямар булчинд хэрхэн үйлчлэх вэ?

1. Түнх ойртуулах (adductor longus/brevis/magnus)

2. Өвдөг нугалах (hamstrings/gastrocnemius)

3. Өвдөг тэнийлгэх (gluteus medius/quadriceps)

4. Тавхай ээтийлгэх (gastrocnemius/tibialis posterior)

5. Хөлийн эрхий хуруу жийх (extensor hallucis longus)

A. Гуяны хайч хэлбэрийг багасгах, эрүүл ахуйг сайжруулах

B. Савлах (swing) фаз дахь алхааны уртыг нэмэгдүүлэх

C. Савлах (swing) фазын эрт үед өвдөг нугалах далайцыг нэмэгдүүлэх

D. Тавхай ээтийлгэх, гадагш эргүүлэх далайцыг нэмэгдүүлэх

E. Хэт тэнийлгэлтийг бууруулах, гутал өмсөх чадварыг нэмэгдүүлэх

A. A1 C2 D3 B4 E5

B. A1 B2 C3 D4 E5*

C. B1 C2 D3 E4 A5

D. B1 A2 C3 E4 D5

E. A1 B2 C3 E4 D5

/294./ Цус харвалтын дараах цочмог үеийн сэргээн засах эмчилгээний арга хэмжээг сонгоно уу?

- A. Амьсгалын замыг хамгаалах, цусны эргэлтийг дэмжих
- B. Тархины хаванг бууруулах, саа саажилтыг сэргээн засах
- C. Аспираци болохоос урьдчилан сэргийлэх, гүний венийн тромбоз үүсэхээс урьдчилан сэргийлэх
- D. Гидроцефалусын эрсдэлийг бууруулах, саа саажилтыг сэргээн засах
- E. Хөдөлгөөний чадвар алдалтыг сайжруулах, нас баралтаас сэргийлэх

/295./ Нуруунд хамгийн бага ачаалал өгдөг байрлалыг олно уу

- A. Нуруу тэгш байрлалд суух
- B. Хойшоо гэдийж суух
- C. Дээш харж хэвтэх
- D. Эгц зогсох
- E. Доошоо тонгойх

/296./ Өвдөгний нугалах хөдөлгөөн хийх үед дөрвөн тойлгойт булчин 180 кг хүчээр үйлчлэн агших далайцыг олно уу?

- A. 115 градус
- B. 60 градус
- C. 45 градус
- D. 5 градус
- E. 25 градус

/297./ Уушгины үлдэгдэл агаарын эзлэхүүн гэж юу вэ?

- A. Амьсгал дээд зэргээр гүнзгий гаргасны дараа уушгинд үлдэх агаарын хэмжээ
- B. Амьсгал тайван аваад тайван гаргах үеийн агаарын хэмжээ
- C. Амьсгал тайван гаргасны дараа уушгинд үлдэх хэмжээ
- D. Амьсгал дээд зэргээр гүнзгий аваад, дээд зэргээр гүнзгий гаргах үе
- E. Амьсгал гүнзгий авсан үед уушгинд байх агаарын хэмжээ

/298./ Уушигны архаг бөглөрөлт өвчний үеийн уушигны багтаамжийн үнэлгээнд суурилсан 3-р үе шатны үзүүлэлтийг нэрлэнэ үү?

- A. $FEV1.0 \leq 50\%$
- B. $FEV1.0 \leq 30\%$
- C. $FEV1.0 \leq 80\%$
- D. $FEV1.0 \geq 80\%$
- E. $FEV1.0 \leq 60\%$

/299./ Стенокардийн босгын тодорхойлолтыг нэрлэнэ үү?

- A. Зүрхний булчингийн хүчилтөрөгчийн хэрэгцээг титэм судас хангаж чадах дээд хэмжээ
- B. Зүрхний булчингийн хүчилтөрөгчийн хэрэгцээг титэм судас хангаж чадах доод хэмжээ
- C. Зүрхний булчингийн хүчилтөрөгчийн максимум зарцуулалт
- D. Зүрхний булчингийн энергийн зарцуулалт
- E. Зүрхний цохилтын максимум хэмжээ

/300./ Ажиллаж буй эд эрхтэний энерги (АТФ) -ийн хэрэгцээг маш богино хугацаанд хангах, ойролцоогоор 1-30 секундын хугацаанд өрнөх нөөцтэй урвалыг сонгоно уу

- A. Фосфаген систем
- B. Анаэробик систем
- C. Аэробик систем
- D. Фосфолипидын задрал
- E. Липидын задрал

/301./ 1 МЕТ гэж юу вэ? Тодорхойлолтыг олно уу.

- A. 1 минутанд 1 кг биеийн жинд 3.8 мл хүчилтөрөгч зарцуулагдана
- B. 1 минутанд 1 кг биеийн жинд 3.5 мл хүчилтөрөгч зарцуулагдана
- C. 1 минутанд кг биеийн жинд 3.5 мл хүчилтөрөгч зарцуулагдахгүй бөгөөд тухайн хүний бие махбодиос хамаарна
- D. Зүрхний эмгэгийн үед зарцуулагдах хүчилтөрөгчийн хэмжээ
- E. Зүрх судасны эмгэгийн үед зарцууагдах нүүрс – усны хэмжээ

/302./ STNR рефлекс хүүхдийн хэдэн сартайгаас эхлэн дарангуйлагдах вэ?

- A. 4 сартай
- B. 5 сартай
- C. 6 сартай
- D. 7 сартай
- E. 8 сартай

/303./ Гуяны арын (hamstring) булчингийн чангарал нь аль үений далайцыг бууруулах вэ?

- A. Түнхний үеэр нугалах
- B. Түнхний үеэр тэнийлгэх
- C. Түнхний үеэр гадагш эргүүлэх
- D. Түнхний үеэр дотогш эргүүлэх
- E. Өвдөгний үеэр нугалах

/304./ Саажилт (paralysis) нь биеийн аль хэсэгт давамгайл үүсдэг вэ?

- A. Тал биеийн саажил (hemiplegy), нугалагч булчингууд
- B. Тал биеийн саажил, тэнийлгэгч булчингууд
- C. Цээжний тэнийлгэгч булчингууд, доод мөчний нугалагч булчингууд
- D. Дээд мөчний нугалагч булчингууд, доод мөчний нугалагч булчингууд
- E. Дөрвөн мөчний тэнийлгэгч булчингууд, нүүрний булчин

/305./ Америкийн зүрхний холбооны эрсдэлт хүчин зүйлийн C-ангилалд орох шалгуурыг сонгоно уу

- A. Биемахбод нь зөвхөн <6 МЭТ эрчимтэй дасгалыг гүйцэтгэх чадвартай байх
- B. Электрокардиограмм болон цусны даралтанд өөрчлөлтгүй байх
- C. Өвчний түүхэндээ ангин, ST сегмент цахилгаан сөрөг шугамаас доошлох
- D. Титэм судасны эмгэгүүд (миокардын шигдээс, титэм судасны цүлхэнгийн мэс засал хийлгэсэн байх, ангина...г.м.)
- E. Зүрхний хавхлагын эмгэг (зүрхний хавхлагын нарийсал...г.м.)

